



Өгэмл

2020 оны дугаар №3

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЛБА



МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛАРЕЙД ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Жил бүрийн 8 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Ням гарагт тохиодог Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны өдрийг тохиолдуулан байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс, 405 дугаар хаалттай хорих ангитай хамтран Монголын уран зургийн галарейтэй хамтран хоригдлуудын урласан бүтээлээр “Миний мөрөөдлийн байшин” үзэсгэлэнг гаргалаа.

Тус үзэсгэлэнд 407, 409, 415 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хорих ял эдэлж буй хоригдлуудын урласан эсгий, цаасан урлал, уран зураг, хатгамал, сийлбэр, уран дархан, наамалаар урласан 50 гаруй бүтээлүүд дэлгэгджээ. Мөн уран зургаар дамжуулж хоригдлыг төлөвшүүлэх ажлын хүрээнд дуу хөгжим, уран зураг хоёрыг хослуулж сэтгэл заслын бясалгалыг явуулсан нь үр дүнтэй болсныг онцолж байна.

Үргэлжлэл нь VI нүүрт



СУРВАЛЖЛАГА:

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж буй хоригдлуудаас улс орны бүтээн байгуулалтад оролцож байна.

Үргэлжлэл нь VII нүүрт



ХОРИГДЛУУДЫГ КЕРАМИК УРЛАЛЫН СУРГАЛТАД ХАМРУУЛЖ БАЙНА

Хоригдлын засрал хүмүүжилд эерэг нөлөөлөл үзүүлэх тэдний мэдлэг боловсрол, бие даах чадварыг сайжруулах цаашлаад өөрсдийн сурч мэдсэн чадвараараа ажлын байр бий болгон нийгэмд бие даан амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор “Керамик урлал”-ын сургалтыг хорих ангийн орчин нөхцөлд зохион байгуулж байна. Тус сургалтад 6 хоригдлыг хамруулж, шавраар бүтээл урлаж байна.


Үргэлжлэл нь VIII нүүрт



“НОМТОЙ НӨХӨРЛӨӨ” АЯНЫ ХҮРЭЭНД

Хорих анги, байгууллагуудад ял эдэлж буй хоригдлуудын мэдлэг боловсрол, өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх, тэдний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “НОМТОЙ НӨХӨРЛӨӨ” 45 хоногийн аяныг зохион байгуулахаар 2020 оны 05 дугаар сарын 15-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа.

Үргэлжлэл нь VI нүүрт



МУУ ЗУРШЛАА ЯЛАН ДИЙЛСЭН ЗАЛУУСЫН УХААРАЛ ХАЙРЛАХ 10 ТҮҮХ

Нэгэнт автсан муу зуршлаа хаях хэцүү. Гэвч ирээдүйнхээ төлөө өөрийгөө ялан дийлж, илүү гэрэл гэгээтэй, сайхан амьдралыг бий болгосон хүмүүс олон. Өөртөө хайргүй хүмүүсийг тавьж явуулах, архи тамхинаас гарахаас эхлээд өдөр тутам хийдэг жижиг зуршлуудыг ч бид давж чадна.

“Тамхинаас гарсан нь”

Тамхинаас гарахаар 2 жилийн өмнө шийдсэн ч гарч чаддаггүй байлаа. Гэвч саяхнаас татах тамхиа өөрөө ороох болсноор бага багаар гарч байна. Тамхи ороох тийм ч хялбар биш тул аажмаар залхуутай санагдаж, тамхийг үзэн ядахад минь тусалж байна гэхэд болно. Дажгүй санаа биш гэж үү? /25 настай Тортега/

Үргэлжлэл нь V нүүрт

“Хүтүүрс амьдралдаа маш олон бүтэцүүтдэй ч, амжилтанд тун ойрхон байгаа гэдгээ ч мэдэхгүй буюрж өгдөг”

ЭРХЛЭГЧ:

Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн дарга, дэд хурандаа Ч.Цэнгэлбаяр

Нарийн бичгийн дарга:

Мэргэжилтэн, хошууч Д.Өлзийсүрэн

Гишүүдэд:

Хорих ял элдүүлэх албаны дэд дарга бөгөөд харуул хамгаалалт, аюулгүй байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа Ч.Мөнх-Эрдэнэ

МСҮТ-ийн захирал, ахмад Х.Батбаяр Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн эрхлэгч, хошууч Х.Баясгалан Ахлах мэргэжилтэн хошууч Ө.Саруултуяа

Мэргэжилтэн, хошууч Н.Болормаа Мэргэжилтэн, ахмад Ч.Дашдэлэг

НАМРЫН УЛИРАЛД ҮҮСЭХ ЯДАРГАА, СЭТГЭЛ САНААНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭРХЭН ЯЛАН ДИЙЛЭХ ВЭ?



Дундад зууны тэртээгээс л улирлын өөрчлөлттэй холбоотойгоор сэтгэл санаа өөрчлөгдөж байгааг анзаарч судалж эхэлсэн байна. Энэ байдлыг Норманн Розенталь 1984 оноос эхлэн нухацтай судалж эхэлжээ. Тэрээр “улирлын шинжтэй сэтгэл санааны өөрчлөлт” гэх нэр томъёог ашиглахыг санал болгов. Намрын улирал ирэх үеэр амттан эсвэл гурилан зүйлд татагдах, эрч хүч дутагдах, нойрмоглох, ихээр ядрах, анхаарал төвлөрөл

муудах, хүнтэй харьцахаас зайлсхийх, бэлгийн дур хүсэл буурах зэрэг шинж тэмдэг илэрч байгаад хавар цаг нэгэнт ирэхэд эргээд хэвийн эрч хүчтэй амьдралдаа эргэж ордог хүмүүсийг хамруулжээ.

Хэрвээ танд дээрх шинж тэмдгүүдээс сүүлийн хоёр жил илэрсэн бол дараах зөвлөгөөг дагахыг хүсэж байна:

1. Мэргэжлийн эмчид хандаж үзүүлэх. Улирлын шинжтэй стрессийг тоолгүй орхиж болохгүй. Магадгүй даамжирсан тохиолдолд өөр бусад өвчний эх үүсвэр болохыг үгүйсгэхгүй.
2. Эмчилгээний зохих аргыг хэрэглэнэ. Үүнд эмчийн бичиж өгсөн эмийг уух, сэтгэл зүйчийн зөвлөгөө авах, гэрлэн эмчилгээг хослуулна. Танд тохирох тодорхой эмчилгээг эмчлэгч эмч хэлж өгнө. Дур мэдэн эмчилгээ хийхийг хориглоно.
3. Амьдралын эрүүл хэв маяг баримтална. Согтууруулах төрлийн ундаа болон өөр бусад муу зуршлаасаа сална.
4. Биеийн идэвхтэй хөдөлгөөнийг байнга дэмжинэ, долоо хоногтоо

3-5 удаа биеийн тамираар хичээллэхийг эрмэлзээрэй. Эрүүл мэндийн асуудалтай бол явганаар явах нь гаж нөлөөгүй.

5. Ажлын байрны таатай нөхцлийг бүрдүүлнэ.

6. Өрөөний засал чимэглэлийн ерөнхий өнгө нь зөөлөн байх бөгөөд тод өнгөөр чимж өгнө – энэ арга нь таны сэтгэл санааг сэргээх эмчилгээний нэгэн төрөл.

7. Үзэл бодлын эрүүл ахуйг хангана. Өөрийгөө дутуу үнэлэх, азгүйтлийн тухай бодлоо хаяж тархиа цэвэрлэх бие даасан эмчилгээ хийнэ. Өөртөө асуулт тавь: тодорхой асуудлыг шийдвэрлэхэд сөрөг үзэл бодол хэрхэн нөлөөлж болохыг төсөөл. Хэрвээ өөрөө бие даан хар бодолтойгоо тэмцэж чадахгүй байвал эмчид хандаж туслалцаа аваарай. Эмч танд энгийн бөгөөд үр дүнтэй эмчилгээний арга техник зааж өгнө.

8. Гунигт автахдаа дуугаа бүү хураа. Өөртөө шигдэх хэрэггүй, асуудлаа найз нөхөд, ойр дотны хүмүүстэйгээ хуваалцаж шаардлагатай бол туслалцаа, дэмжлэг ав. Танд тустай зөвлөгөө өгч чадахгүй ч гэлээ тэд таны сэтгэлийг ойлгоно.

Эх сурвалж: news.xopom.com

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖҮҮД



Томуу, томуу төст өвчин нь вирусээр үүсгэгддэг амьсгалын цочмог халдварт өвчин юм. Амьсгалын замын цочмог халдварт өвчин нь халуурах, толгой өвдөх, ханиалгах, хамраас нус гоожих, үе мөч, булчингаар өвдөх буюу ерөнхий хордлогын шинжээр илэрдэг.

Ханиад томуу болон агаар дуслын замаар халдварладаг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга бол дархлаажуулалт юм. Мөн бага насны хүүхдийнхээ эрүүл мэндэд онцгой анхаарч, ханиад

томуунаас урьдчилан сэргийлэх бусад арга замуудын талаар Нийслэлийн эрүүл мэндийн газраас гаргасан энэхүү зөвлөмжөөс сонирхоорой.

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНӨӨС ХЭРХЭН СЭРГИЙЛЭХ ВЭ?

- Өвчлөлөөс сэргийлэх хамгийн сайн хамгаалалт нь биеийн эсэргүүцэл сайн байх явдал тул витаминлаг чанарлаг хоол идэх, биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг эрхэмлэн, ажил амралтаа зохицуулж, хангалттай амрах
- Улирлын байдалд тохируулан хувцаслах, хүйтэнд малгай, ороолт, бээлий хэрэглэх
- Шаардлагагүй тохиолдолд олон нийтийн газар явахгүй байх
- Хамрын салстад сонгино, сармисны тосон ханд, оксолины тос түрхэх
- Гичтэй бүлээн усанд хөлөө 5-10 минут дүрж, хөлийн уланд тосон иллэг хийх
- Витамин С-ээр элбэг жимс болон шүүс, витамин С-г хэрэглэх
- Өдөрт 2-3 хумс сармисыг хоол ундандаа хэрэглэх


- Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх цэгчилсэн иллэг хийх
 - Царван, морин шарилжны ханд, содтой болон давстай ус, тамидин зэрэг уусмалаар хоолойгоо тогтмол зайлж хэвших
- Эдгээр энгийн аргуудыг хэрэглэхээс гадна ТТӨ-нөөс сэргийлэх үндсэн гол арга бол томуугийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад хамрагдах явдал юм. Тиймээс та бүхэн ХӨСҮТ-ийн сайн дурын дархлаажуулалтын кабинетаар үйлчлүүлээрэй. Ялангуяа 2-15 хүртэлх насны хүүхэд, өндөр настан, уушгины архаг суурь өвчтэй хүмүүс хамрагдвал илүү ач холбогдолтой.

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ЯАХ ВЭ ?

- Эмнэлэгт яаралтай хандаж, эмчийн зөвлөгөөг ягштал баримтлан хэвтрийн дэглэм сахих
- Халуун аарц, чацарганы шүүс, сармистай хар шөл зэрэг амаар уух шингэнийг түлхүү хэрэглэх
- Амны хаалт байнга зүүж хэвших
- Гараа сайтар савандаж угаах хэвших, хүүхдийн тоглоом, аяга, халбага болон шүдний сойзыг өдөр бүр содын уусмалаар ариутгах
- Үзвэр үйлчилгээ, олон нийтийн газар, сэлгүүцэхгүй байх
- Томуу, томуу төст өвчний үед эмийг эмч болон эм зүйчийн өгсөн зааврын дагуу хэрэглэх, дур мэдэн антибиотик хэрэглэхээс зайлсхийх
- Өвчилсөн тохиолдолд колдаур, колдакс, фервекс, минигрипп, миксогрипп, антигрипп, интерферон, аньсны шүүс зэргийг өвчний эхний 3 хоногт зааврын дагуу ууж хэрэглэх
- Томуу, томуу төст өвчний үед вирусст сонгомол үйлчлэх эмүүдэд: интерферон, ремантадин, амандатин, тамифлю, оксолины түрхлэг орно.
- Томуу, томуу төст өвчинд шинж тэмдгийн эмчилгээ хийнэ. Үүнд: халуун бууруулах, ханиалга намдаах, амьсгалын замыг чөлөөлөх, хордлого тайлах шингэн хэрэглэх, ардын уламжлалт тан ууж болно.

Эх сурвалж: Нийслэлийн эрүүл мэндийн газар

ЭРҮҮЛ МЭНД



ТАНИН МЭДЭХҮЙ

ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ МЭНДЭЛСЭН ӨДӨР БҮЮУ “МОНГОЛ БАХАРХАЛ”-ЫН ӨДӨР

Монгол бахархлын өдөр нь Монгол Улсад 2012 оноос бүх нийтийн амралтын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж буй баярын өдөр юм.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 4 тоот зарлигаар эзэн богд Чингис хааны мэндэлсэн огноог холбогдох ажлын хэсгийн дүгнэлт болон ШУА-ны саналд үндэслэн албан ёсны болгож, билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн гэж тогтоон, уг өдрийг “Монгол бахархлын өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлж байхаар болсон юм.

Энэ өдрийг тохиолдуулан жил бүр улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг гүнзгий судалж, хойч үедээ өвлүүлэх, тэдгээрийг дэлхий дахинд сурталчлан таниулах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, төр, нийгэм, үндэстний өмнө онцгой гавьяа байгуулсан нэг иргэнийг Монгол Улсын төрийн дээд шагнал-тэргүүн зэргийн одон “Чингис хаан” одонгоор шагнадаг уламжлалтай.



Монгол бахархлын өдрөөр Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг цэнгүүлэх ёслол болж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэн, чансаа өндөр хүчит бөхийн барилдаан болдог.

Монгол бахархлын өдөр хэзээ вэ? Ойрын жилүүдэд тохиох өдрүүд, нийтийн он тоолоор


Өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн нь билгийн тоолол учир аргын тоололтой нийцүүлэн тэмдэглэхэд жил бүр өөр өдөр тохиож байгаа юм.

- 2012 он: 11 сарын 14, Их эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойн өдөр
- 2020 он: 11 сарын 16, 858 жилийн ойн өдөр
- 2021 он: 11 сарын 5, 859 жилийн ойн өдөр
- 2022 он: 11 сарын 24, 860 жилийн ойн өдөр.

УЛС ТУНХАГЛАСНЫ ӨДӨР

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Хаант засгаас Бүгд найрамдах засаглалд шилжиж, хамжлагат ёсыг халан, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулсан нь Монголын түүхийн асар том үйл явдал юм.

Анхдугаар Үндсэн хууль батлагдсан нь нийгэм эдийн засгийн олон ололтыг манай улсад бий болгон батжуулсан төдийгүй Монголын газар шороо, хөрсөн доорх баялаг, ой мод, ан амьтан зэргийг ард түмний өмч гэж зарлаж байжээ. Түүнчлэн иргэдийн сонгох сонгогдох эрхийн асуудлыг хуульчлан, Азид анх удаа Монгол Улс эмэгтэйчүүд эрчүүдтэй адил тэгш эрхтэй байх явдлыг хангаж өгсөн юм.



Харилцан шүтэлцээ бүхий энэхүү түүхэн үйл явдлын үр шимээр өнөөдөр монголчуудын эдэлж буй олон эрх, эрх чөлөөг хуульчлан тогтоосон байдаг. Тухайлбал, бүх нийтээрээ бичиг үсэгт суралцах, эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил эрх тэгш байх, шашин шүтлэг болон хэвлэн нийтлэх эрх чөлөөний суурь чухам энэ цаг үеэс л тавигджээ. Иймд он цагийн урсгалд баларч гээгдэхийн аргагүй энэ түүхэн үйл явдал бол 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр тохиож Монголын түүхэнд бичигдэж үлдсэн юм.

Монгол Улсыг тусгаар тогтносон улс болоход томоохон хувь нэмэр оруулсан анхны Үндсэн хууль мэндэлсэн, хамжлагат ёсыг халан хаант засгаас Бүгд Найрамдах засаглалд шилжсэн баярыг монголчууд хотол олноороо тэмдэглэх нь ихээхэн ач холбогдолтой юм. Дэлхийд данстай бүх улс дотоодын хэм хэмжээг зохицуулах тулгуур хуультай, тэрхүү хуулийг батлан мөрдсөн өдрийг ард нийтийн баяр болгон тэмдэглэдэг уламжлалтай.

Манай улс Бүгд Найрамдах Улс тунхагласны баярын өдрийг нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон ёслол төгөлдөр тэмдэглэж ирсэн уламжлалтай ч 2012 оноос уг өдрийг “тэмдэглэлт өдрийн” түвшинд өнгөрөөх болсон юм. Энэ нь түүхийн чухал үйл явдлын ач холбогдлыг багасгаж, түүх уламжлалыг бүдгэрүүлэх алдаатай шийдвэр болсныг ард иргэд шүүмжлэн, эрдэмтэн судлаачид байр сууриа илэрхийлсээр байгаа тухай хууль санаачлагчийн илтгэл танилцуулсан юм. Иймд УИХ-ын гишүүн Я.Содбаатар нарын 9 гишүүнээс Бүгд Найрамдах Улс тунхагласны баярын өдрийг “Нийтээр тэмдэглэх баярын өдөр” болгон сэргээж хуульчлахаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр УИХ-д өргөн барьсан юм.

Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэний дараа Төрийн байгуулалтын байнгын хороо анхны хэлэлцүүлгийг хийхдээ “анхны хэлэлцүүлгээр нь батлах” санал гаргасан юм. Уг саналыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдрийн хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх нь дэмжиж, 83,7 хувийн саналаар хуулийг баталлаа. Уг хууль батлагдаж буйтай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуульд мөн өөрчлөлт оруулж батлав. Хуулийн төсөлтэй холбогдуулан Н.Энхболд гишүүн “Энэ бол зүгээр нэг бүх нийтийн амралтын өдрийн тухай асуудал биш. Энэ бол түүхийн, бахархлын, цаашлаад тусгаар тогтнолын баталгааны асуудал. Бид ийм баталгаа, дархлаатай, ой санамжтай улс гэдгийг батлан харуулах ач холбогдол энэ хуулийн цаана бий” гэсэн юм.



Ингээд уг хууль батлагдсанаар жил бүрийн 11 дүгээр сарын 26-ныг “Улс тунхагласны баяр” хэмээн зарлаж, бүх нийтийн амралтын өдөр болгон, тэмдэглэн өнгөрүүлдэг боллоо. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд “нийтээр тэмдэглэх баярын өдөр” гэж улс орны хэмжээнд нийтээр амарч, баяр болгон тэмдэглэдэг өдрийг, “нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр” гэж түүхэн болон тодорхой үйл явдалтай холбоотой, нийгмийн тодорхой давхаргыг хамарсан, бүх нийтээр тэмдэглэж заншсан өдрийг тооцож байгаа юм.

ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ, ТУСГААР ТОГТНОЛОО СЭРГЭЭСНИЙ БАЯРЫН ӨДӨР



1911 оны цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн буюу аргын тооллын 1911 оны 12 дугаар сарын 29-нд Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон Монголчууд үндэсний тусгаар тогтнолоо зарлаж, VIII Богдыг Монгол улсын шашин төрийг хослон баригч, хэмжээгүй эрхт хаанд өргөмжилж түүнд төрийн тамга, төрийн далбаа, өргөмжлөл, хүндэтгэлийг өргөж, таван яам бүхий засгийн газрыг байгуулах түүхэн шийдвэр гарган, тусгаар тогтносон Богд хаант Монгол улсыг байгуулсан юм. Монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь төрт ёсны өнө эртний уламжлалтай Монголын ард түмний түүхийн онцгой хуудас, хойч үе нь бахархан дурсвал зохих түүхт үйл явдал мөн. Энэхүү Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Монголчуудын туурга тусгаар улсаа сэргээн байгуулах гэсэн олон арван жилийн мохошгүй хүсэл тэмүүлэл, тууштай тэмцлийн биелэл, үндэсний ухамсрын их сэргэлтийн эхлэл, 1921 оны Ардын хувьсгалын бодит хөрс болсон билээ.

Социализмын он жилүүдэд энэхүү түүхэн чухал өдрийн үнэ цэнийг ойшоолгүй ирсэн ч УИХ-н 2007 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар 12 дугаар сарын 29-ний өдрийг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр болгон улмаар 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр хэмээн нийтээр тэмдэглэх баярын өдөр болгохоор хуульчилж нийтээр амардаг болсон.

“ХҮҮХДИЙН БАЙШИН” БҮЮУ ЦЭЦЭРЛЭГ БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ

1932 онд Ардыг гэгээрүүлэх яамны сайдын тушаалаар хотын гэгээрлийн хэлтсийн шууд харьяанд байх 8 төрлийн ажилд “Хүүхдийн байшин” гэсэн заалт оруулсан нь хүүхдийн цэцэрлэгийн тухай байсан бөгөөд тэр үед цэцэрлэгийг ийнхүү нэрлэдэг байжээ. Эхэн үедээ цэцэрлэгийн хүүхдийн ирц нь тогтворгүй цөөн хүүхэдтэй байжээ.



“Өнгөрсөн оны эхээр 40 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байсан бол одоо 23 хүүхэдтэй болов. 40 хүүхдийн нэлээд нь орос хүүхэд. Эцэг эх нь гар дээрээ авснаас хүүхэд цөөхөн болов. Сүү олох нь бага, үнэ нь их, бусад зүйл зүгээр” хэмээн хотын Гэгээрлийн хэлтсээс 1933 онд гаргасан тайланд дурдсан байна.

Улаанбаатар хотын нэгдүгээр цэцэрлэг 1932 онд одоогийн I сургуулийн хойно орос маягийн цонхтой, тухайн үедээ нэлээд тохилог тооцогдох томоохон мяндаг тушаалтай ламын амьдарч байсан байшинд нүүн оржээ. Уг цэцэрлэг хотын гэгээрлийн хэлтсийн харьяанд байсан учир хангамж сайтай нэг үнээ, 10 гаруй тахиатай байв. Анхны цэцэрлэгүүдэд юм хайчилж наах, хөл гарын сургууль хийх, өнгө, зүг чиг заах, хүмүүсийн зураг үзүүлж түүх намтар ярих, малын хүйс, нас зэргийг заахаас гадна мандолин, бөмбөр зэрэг хөгжим тоглохыг заадаг байв. 1940-өөд оны үед цагаан шаврыг загасны тос, сонингийн цаастай хольж, баримлын хичээл хийлгэдэг болжээ. 1941 он гэхэд Монгол улсад 14 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байсны 8 нь Улаанбаатар хотод ажиллаж байлаа. Энэ үеийг хүртэл хүүхдийг цэцэрлэгт татах нэг арга нь үнэгүй хооллох байсан бол “Хүүхдийн цэцэрлэгт хүмүүжүүлэх багачуудын хоолны зардлыг эцэг эхээс гаргуулах тухай” Сайд нарын зөвлөлийн 20 дугаар тогтоол 1942 оны 5 дугаар сарын 21-нд гарч зарим нөхцөлд эцэг эхээс гаргуулах болжээ.

Уг тогтоолд “а). Гэр бүлийн хүмүүс нь ажил хийж, цалин авдаг



бөгөөд хэрэв нэгэн хүүхэд цэцэрлэгт явдаг аваас бүх авах цалин бүгд ам бүлд хувааж, ам бүлийн нэг хүнд оногдох цалингийн хэмжээний зууны 25 хувиар бодож төлбөл зохино. б). Гэрийн доторх хүмүүс цөм хөдөлмөрлөж цалин хэрэглэл авдаг бөгөөд хэрэв цэцэрлэгт 2 буюу түүнээс дээш хүүхэд явдаг бол бүх цалин бүгд ам бүлд хувааж, ам бүлийн нэгэн хүнд оногдох цалингийн зууны 25 хувиар 1 дүгээр хүүхдийн зардлыг гаргуулах ба бусад хүүхдийн зардлыг 15 хувиар бодож гаргана. в). Хөдөлмөр хийж чадахгүй эцэг эхийн хүүхдийг цэцэрлэгийн газар хооллуулах явдлыг улсын зардлаар гүйцэтгэнэ” хэмээн заажээ.

ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

ХУУЛИЙН МЭДЛЭГТ



Хууль зүйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/189 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцид нийцүүлэн Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэх /цаашид "Үндэсний жолоочийн үнэмлэх" гэх/, Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх /цаашид "Олон улсын жолоочийн үнэмлэх" гэх/ олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Жолоочийн үнэмлэх олгох ажлыг нийслэлд Цагдаагийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох ажил хариуцсан нэгж, орон нутагт тухайн нутаг дэвсгэр хариуцсан замын цагдаагийн нэгж /цаашид "Цагдаагийн байгууллагын эрх бүхий нэгж" гэх/ хариуцна.

1.3. Монгол Улсын үндэсний болон олон улсын жолоочийн үнэмлэх нь Монгол улсын жолоочийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн төлөв, жолоочийн бүртгэлийн хуудсаар баталгаажна.

Хоёр. Жолоочийн үнэмлэх олгох үйл ажиллагаа

2.1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий нэгж нь жолоочийн үнэмлэх олгохтой холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. жолоодох эрхийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн иргэнд тохирох ангиллын үндэсний жолоочийн үнэмлэх олгох;

2.1.2. жолоочийн бүртгэл, мэдээллийн санг хөтөлж, мэдээллийг ашиглах, нууцлалыг хадгалах, жолоочийн тухай лавлагаа гаргах;

2.1.3. хууль тогтоомжид заасны дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах, сэргээх явцад жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгох, устгах, нөхөж олгох;

2.1.4. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орнуудаас олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын жолоочийн үнэмлэхээр солих;

2.1.5. Монгол Улсын Олон улсын жолоочийн үнэмлэх олгох;

2.1.6. жолоочийн үнэмлэхний хугацаа дууссан иргэнд үнэмлэхийг шинээр олгох.

2.2. Монгол Улсын үндэсний болон Олон улсын жолоочийн үнэмлэхийг өөрт нь, эсвэл итгэмжлэл бүхий иргэн, хуулийн этгээдэд олгож болно.

Гурав. Үндэсний жолоочийн үнэмлэх олгох

3.1. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт өгч тэнцсэн иргэнд дараах материалыг үндэслэн үндэсний жолоочийн үнэмлэх олгоно:

3.1.1. иргэний үнэмлэх, гадаадын иргэн бол гадаад паспорт;

3.1.2. тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журамд заагдсан үнэлгээний хуудас;

3.1.3. эрүүл мэндийн тодорхойлолт;

3.1.4. өнгөт цээж зураг 3x4 хэмжээтэй, 1 хувь;

3.1.5. үнэмлэхний үнэ төлсөн баримт.

3.1.6. Гадаад улсын жолоочийн үнэмлэхний Монгол хэл дээр хөрвүүлсэн баталгаат орчуулга. /гадаад улсын жолоодох эрхийн үнэмлэх солих тохиолдолд/ /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар нэмэлт орсныг тусгав/

3.2. Үндэсний жолоочийн үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн, хүчинтэй хугацаа нь дуусгавар болсон тохиолдолд нөхөж буюу сольж олгох бөгөөд ийнхүү олгоход энэ журмын

3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.6 дахь хэсэгт заасан үнэлгээний хуудас, эрүүл мэндийн тодорхойлолт, цээж зураг, баталгаат орчуулга шаардахгүй. /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар өөрчлөлт орсныг тусгав/

3.3. Тодорхой шалтгааны улмаас /үнэмлэх хэвлэх үйл ажиллагаа тасалдсан, зогссон гэх мэт/ үндэсний жолоочийн үнэмлэхийг хэвлэж олгох боломжгүй үед энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн түр зөвшөөрөл /цаашид "түр зөвшөөрөл" гэх/-ийг 3 сар хүртэл хугацаатай олгож болно.

3.4. Түр зөвшөөрөл олгосон жолоочид үндэсний жолоочийн үнэмлэхийг хэвлэж олгоходоо энэ журмын 3.1-д заасан материал бүрдүүлэхийг шаардахгүй.

3.5. Түр зөвшөөрөл нь үндэсний жолоочийн үнэмлэхтэй нэгэн адил хүчинтэй байх бөгөөд жолоочийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдэж баталгаажсан байна.

3.6. Үндэсний жолоочийн үнэмлэх хэвлэж, олгосон тохиолдолд түр зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно.

3.7. Гадаадын иргэн Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орноос олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхээ Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэхээр солиулах хүсэлт гаргасан тохиолдолд тохирох ангиллын үнэмлэхээр шууд сольж олгоно.

3.8. Энэ журмын 3.7 дахь хэсэгт заасан үндэслэлээр Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэхийг сольж олгох явцад ангиллын зөрүү гарвал үндсэн ангиллыг баримталж, Монгол Улсын иргэнд 10 жил, гадаадын иргэнд тухайн орны жолоодох эрхийн үнэмлэхний хүчинтэй хугацаагаар олгоно. ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар өөрчлөлт орсныг тусгав/

3.9. Монгол Улсад суугаа Элчин сайдын яам болон Консулын газрын дипломат төлөөлөгчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хүсэлтийг үндэслэн түүнд жолоочийн үнэмлэхтэй нь тохирох ангиллын үндэсний жолоочийн үнэмлэхийг шууд олгож болно.

3.10. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн бус орноос олгосон жолоодох эрхийн үнэмлэхтэй гадаадын иргэнд энэ журмын 3.1-д заасныг баримтлан тухайн орны жолоодох эрхийн үнэмлэхний хүчинтэй хугацаагаар, Монгол Улсын иргэнд 10 жилийн хугацаагаар үндэсний жолоочийн үнэмлэх олгоно. /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар өөрчлөлт орсныг тусгав/

3.11. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн бус орноос олгосон жолоодох эрхийн үнэмлэхтэй гадаадын болон Монгол Улсын иргэн энэхүү журмын 3.1-т заасан материалыг бүрдүүлж жолоочийн үнэмлэх авна. /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар хассан/

Дөрөв. Монгол Улсын олон улсын жолоочийн үнэмлэх олгох

4.1. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орноос олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэх бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн хүсэлт гаргасан тохиолдолд олон улсын жолоочийн үнэмлэх олгож болно.

4.2. Олон улсын жолоочийн үнэмлэх авах хүсэлт гаргасан Монгол улсын иргэнд дараах бичиг баримтыг үндэслэн олгоно:

4.2.1. хүсэлт;

4.2.2. үндэсний жолоочийн үнэмлэх эсхүл иргэний үнэмлэх; /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар өөрчлөлт орсныг тусгав/

4.2.3. иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, эсхүл иргэний үнэмлэхний цахим лавлагаа; /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар хассан/

4.2.4. үндэсний жолоочийн үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар; /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар хассан/

4.2.5. өнгөт цээж зураг 3x4 хэмжээтэй, 2 хувь; /ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар хассан/

4.2.6. олон улсын жолоочийн үнэмлэхний үнэ төлсөн баримт.

4.3. Олон улсын жолоочийн үнэмлэх авах хүсэлт гаргасан гадаадын иргэнд дараах бичиг баримтыг үндэслэн олгоно:

4.3.1. хүсэлт /монгол хэл дээр/;

4.3.2. үндэсний жолоочийн үнэмлэхний лавлагаа; ХЗДХС-ын 2018 оны А/23 дугаар тушаалаар өөрчлөлт орсныг тусгав/

4.3.3. гадаад паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.3.4. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орноос олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоочийн үнэмлэх түүний монгол хэл дээр хөрвүүлсэн албан ёсны орчуулга, эсхүл Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэх, тэдгээрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.3.5. өнгөт цээж зураг 3x4 хэмжээтэй-1 хувь, 4x6 хэмжээтэй -1 хувь;

4.3.6. олон улсын жолоочийн үнэмлэхний үнэ төлсөн баримт.

Тав. Бусад

5.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.3 дахь хэсэгт заасан жолоочийн бүртгэл, мэдээллийн санд жолоочийн үнэмлэх шинээр болон нөхөн олгосон, ангилал нэмсэн, эрх хассан болон сэргээсэн, зөрчлийн оноо, олон улсын жолоочийн үнэмлэх, түр зөвшөөрөл олгосон мэдээллийг оруулна.

5.2. Жолоочийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг Цагдаагийн байгууллага хариуцна.

5.3. Жолоочийн бүртгэл, мэдээллийн сан нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан, бэлэн бус торгуулийн болон шаардлагатай бусад мэдээллийг нэгтгэсэн, тэдгээртэй уялдан ажиллах чадвартай байна.

5.4. Жолоочийн үнэмлэхийг хүлээлгэн өгсөн, устгасан тухай тэмдэглэл үйлдэж, оролцогчид гарын үсэг зурсан байна.

5.5. Жолоочийн үнэмлэхийг олгосон болон эрх сэргээсэн тухай гар бичмэл, үнэлгээний хуудас, холбогдох материалыг Үндэсний архивын газрын даргын баталсан "Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийг хадгалах хугацааны үлгэрчилж жагсаалт"-ын дагуу хадгална.

5.6. Энэхүү журмыг зөрчсөн Цагдаагийн алба хаагч болон иргэнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

Жолооны үнэмлэх нөхөн олгох, солих



ҮНЭМЛЭХ ҮРЭГДҮҮЛЖ ШИНЭЭР ХЭВЛҮҮЛЭН АВАХ БОЛ

Жолоочийн үнэмлэх үрэгдүүлсэн бол дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Цагдаагийн байгууллагаас оногдуулсан бэлэн бус торгуульгүй байх, хэрэв торгуультай бол төлсөн байх шаардлагатай.

2. Иргэний үнэмлэх, эсхүл иргэний үнэмлэхийн лавлагаа.

3. Жолооны үнэмлэхний төлбөр 12,500 төгрөг тушаасан баримт. /Дансны дугаар: 100900012520, Хүлээн авагч банк - Төрийн сан, Хүлээн авагч байгууллага - ЦЕГ-ын жолооны үнэмлэх орлого, Гүйлгээний утга - овог, нэр, регистрын дугаар/

ТАНЫ ЖОЛООНЫ ҮНЭМЛЭХНИЙ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА ДУУССАН, ЭСВЭЛ ХУУЧИРЧ МУУДСАН ҮНЭМЛЭХ СОЛИУЛАХ БОЛ

Жолоочийн үнэмлэх хуучирч муудсан, хуучин шар үнэмлэх болон хугацаа дууссан жолооны үнэмлэх солиулах бол дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Та цагдаагийн байгууллагаас оногдуулсан бэлэн бус торгуульгүй байх ёстой. Хэрэв торгуультай бол заавал төлсөн байх ёстой.

2. Хугацаа дууссан эсвэл хуучирч муудсан жолооны үнэмлэхтэй ирнэ.

3. Жолооны үнэмлэхний төлбөр 12,500 төгрөг тушаасан баримт. /Дансны дугаар: 100900012520, Хүлээн авагч банк - Төрийн сан, Хүлээн авагч байгууллага - ЦЕГ-ын жолооны үнэмлэх орлого, Гүйлгээний утга - таны овог, нэр, регистрын дугаар байна./

УРАН ЗОХИОЛ

Харуусал



Түүнд амьдрал хэтэрхий хатуу, өршөөлгүй мэт санагдана. Эргэн тойрны бүх л зүйлс өнгөгүй харанхуй харагдаж, голдрилоо даган урагшлах их хотын хөдөлгөөнт амьдрал, юунд ч юм яаран алхах хүмүүсийн аль нь ч түүний сэтгэлийг эс хөдөлгөж гагцхүү үзэн ядалт, хязгааргүй харууслыг төрүүлэх нь юуны учир вэ? Түшиг ээжийнхээ ганц нар нь билээ. Ухаан орохоосоо л ээждээ өмөг түшиг болж, уйлах дуулах алин бүхэнд гагц ээжээрээ л аргадуулж, ээжийн өврийг булаалдах ахан дүүгүй, өндөрт өргөөд өхөөрдөн үнсэх аавгүй өссөн болоод ээждээ тэр амин голоосоо хайртай. Түүний ээж дарь эхийн хувилгаан гэлтэй сайхан эмэгтэй бүх л амь амьдралаа хүүдээ зориулж, өндгөө дарсан шувуу мэт үрээ бөөцийлөн бөмбөрүүлж өсгөхдөө, жаргал зовлонгийн алинд ч барьц үл алдах сэтгэлийн тэнхээтэй эр хүн болгож хүмүүжүүлэхийг зорьсон билээ. Ээж хүү 2 үдэш бүр ганцхан үлгэр ярилцана. Тэр үлгэрт хүү эрийн цээнд хүрч, эхнэр аваад өнөр өтгөн сайхан амьдарч, өндөр настай ээжтэйгээ энх тунх, мөнх жаргасан тухай өгүүлдэг юм. Ээжийнхээ үлгэрийг шимтэн сонссон Түшиг хүү: -Ээжээ би ийм олон хүүхэдтэй болно гээд гар хөлийнхөө 20н хурууг оролцуулан тоолоод ч түүний мөрөөдөж явдаг олон хүүхдийн талд ч хүрдэггүй болохоор ээжийнхээ гар хурууг оролцуулан байж сая нэг сэтгэл амардагсан...

Түшиг нэр шигээ сайхан залуу. Туйлын цэвэрхэн царай, боловсон зан, ухаалаг яриатай түүнд унан тустлаа дурлаж ил далдуур эргүүлэх охид захаас аван байх авч угаас эмэгтэй хүнийг бурхан лугаа хүндэлдэг сайх залуу охидын гэнэн сэтгэлээр зугаацан тоглохыг огтхон ч хүсэхгүй байсаар намрын нэгэн налгар өдөр ээждээ үнсүүлэн, хонгор бүсгүйчүүдийн итгэл хүлээлтээр үдүүлэн харийн нутаг руу эрдмийн их аянд мордов. Хүний нутаг хатуу ч угаас сэргэлэн тэрээр төдий л барьц алдсангүй. Амьдрах орчин , ажил үйлс нь урьдаас захиалсан мэт амархан төвхнөж, төрж өссөн Монголоос нь төдий л ялгаагүй санагдах болсон ч хүүгээ хүлээн ганцаар хоцорсон ижийгээ

санах нь Түшигийн сэтгэлд хэцүү байлаа. Эгэл жирийн өдрүүд урсан өнгөрч сурахын зэрэгцээ нэгэн диско клубт зохион байгуулагчаар ажилласаар 2 жилийг ардаа үдсэн хаврын нэгэн өдөр сэтгэл гэгэлзүүлж, зүрх догдлуулсан хосгүй учрал тохиосон юм. Тэр дурлалчидээ. Үзэсгэлэн гоогоо гайхуулан, уян налархай тайчин бүжиглэгч харийн бүсгүйд сэтгэл алдан, залуу насны гал халуун дурлалдаа мансууран жаргаж явахдаа нүдээ олоогүй нүгэлт хайр түүний амьдралд хар зам татуулан айсуйг ухаарах нь атугай зүүдэлж ч явсангүй. Нандин хайртайгаа учрав гэж сэтгэл хөөрөн явахдаа сэтгэлт харь бүсгүйдээ хар нүдээ ч ухааж өгөхөөс буцахгүй хамаг бүхнээ зориулан, хамтын амьдралаа төвхнүүлэх гэж хичээн зүтгэж явахдаа хайртай ээжийгээ мартаж дөхсөн нь хачирхалтай.

Аз жаргалтай өдрүүд төдий л удаан үргэлжилсэнгүй. Түшигийн дурлалт бүсгүй харь сэтгэл гарган хааяа гадуур тэнэхдээ хар тамхи хэрэглээд зогсохгүй болох бүтэхгүй хүмүүстэй нөхөрлөж элдвийн хэрэг өдүүлдэг танхай хүүхэн байжээ. Тэр ч байтугай нэгэн үдэш хар тамхины наймаачин гэх мансуурсан залуус Түшигийн өрөөнд халдан ирж:-Чиний хүүхний хэрэглэж мансуурсан тамхины тооцоо. Одоохон төлөхгүй бол цагаач төлөг чамайг энэ донтой хүүхэнтэй чинь цааш харуулна хэмээн буу зэвсгээр айлган сүрдүүлж, хамаг өнгөтэй бүхнийг нь авч одсон удаатай. Энэхэн үеэс л харийн нутаг хатуу, хүний сэтгэлийн хүйтнийг ухаарсан монгол залуу хойшдын замаа эргэцүүлэн бодож, эр хүний харам нулимсаа тэвчиж үл чадан эх сайхан нутгаа элэг зүрхнээсээ үгүйлэн санасан билээ. Тэгээд л нэгэн өдөр бүхнийг орхин нутагтаа гүйсэн морин адил ижийгээ зорин ирсэн юм... Энэ яваа насандаа хал үзэж, халуун чулуу долоосон нь нүүрэндээ илхэн эл буурал эмч түүнийг халгаж өрөвдсөн нүдээр ширтэн сууснаа, эр хүний хатуу зангаар: -Хүү минь чи залуу насаа хайрлахгүй яав даа! гэхэд аль түрүүнээс яс нь хавталзаж суусан Түшиг ихэд цочирдож, 2 чихэндээ үл итгэн горьдлого дүүрэн харцаар эмч рүү харахад,

хөөрхий тэр буурал өөрөө л буруутан мэт газар ширтэн: -Хүндрэх шатандаа орчихсон байна шүү дээ хэмээн арга нь барагдсан өнгөөр хэлэв. " Өдий хүртэл бодохоос ч айж ичин, хар дарсан зүүдэндээ ч харж яваагүй тэр аюулт тахлын нянг тээгч болчихлоо гэж үү?. Монголын ...дэх тохиолдол. 28 настай, өндөр боловсролтой, бизнесмэн залуу.

Бурхан минь та намайг яагаад ингэж хүндээр шийтгэж байгаа юм бэ?". Зүрх нь ийн цусаар уйлж байлаа. Навчис хөглөрөн намрын сүүлчийн бороо цонхны гадаа асгарна. Энээ үгүйлэх тэмдэглэлийн дэвтэр, элэгдэж хуучраагүй бичгийн ширээ, эмх цэгцтэй саруулан өрөө нэг л уйтай. "Өглөө бүр үнсэн сэргэж, өгөөмөр хайраар тэтгэн, залуу насны жаргалаа огоорч зөвхөн үрээ л гэж явсан ачлалт ээжийгээ сэтгэлийн зовлонд учруулж, ганц олдох амьдралыг нь там болгохоор төрсөн буг чөтгөр гэж үү би. Монгол сайхан бүсгүйн заяаг гомдоож сохор мэт өнгөрсөн буруу санаат миний нүгэл нүдээрээ гарч бурхнаас ийм шийтгэл оноогоо биз ээ. Суут Чингисийн удмын дайчин цөст Монгол хүмүүн атлаа мөнх хөх тэнгэртээ тэрсэн харийн орныг диваажинд тооцон, холимог цустныг бурханд бодож яваа хэн боловч тэнгэр талаа, тоонот гэрээ, туурт хүлгээ зорин заавал ирээдэй. Энд чамайг ээжий аав тань, элэг бүтэн гэр бүл, элгэн садан Монголчууд чинь хүлээж суугаа шүү!". Тэмдэглэлийн дэвтэрт эр хүний хатуу нулимсаа тэвчин байж бичсэн гаргацтай мөрүүд зурайна. Үг, үсэг бүрээс түүнийг эрэхдээ үүлэн чөлөөний наран адил үзэгдээд өнгөрсөн амьдралынх нь уярал ухаарал, харамсал харууслыг олж мэдэрсэн хэдий ч мартамгүй сайхан инээмсэглэл, хүүхэд шиг цайлган томоогүй тэр нэгэн сайхан хүнтэй эргэн учрахгүй гэхээс сул асгарах нулимсан дуслууд энгэр нэвтлэн норгож, энэрэлгүй хатуу хорвоогийн өчүүхэн тоглоом мэт хүмүүн заяагаа үгүйсгэн үзэн ядмаар. Гэвч амьдрал үргэлжилсээр л...

ЗОХИОЛЧ А.НАРАНГАРАВ

МЦҮ ЗҮРШЛАА ЯЛАН ДИЙЛСЭН ЗАЛЦУСЫН ЦХААРАЛ ХАЙРЛАХ 10 ТҮҮХ

Нэгэнт автсан муу зуршлаа хаях хэцүү. Гэвч ирээдүйнхээ төлөө өөрийгөө ялан дийлж, илүү гэрэл гэгээтэй, сайхан амьдралыг бий болгосон хүмүүс олон. Өөртөө хайргүй хүмүүсийг тавьж явуулах, архи тамхинаас гарахаас эхлээд өдөр тутам хийдэг жижиг зуршлуудыг ч бид давж чадна.

1. "Хийжүүлсэн ундаанаас гарсан нь"

Бага байхаасаа л би оройн хоолны үеэр нэг аяга (заримдаа 2 аяга) хийжүүлсэн ундаа уучихдаг байв. Өсвөр насанд хүрэхэд шүд цоорч, ходоод өвдөх болсноор энэхүү хорт зуршлаа хаяхаар шийдсэн. Шууд орхин маш хэцүү байсан учир эхний долоо хоногт хийжүүлсэн ундааг хүүсээр сольж, дараагийн долоо хоногт нь усаар сольсон. Одоо бол хоолны үеэр шингэн юм уудаггүй. 30 минутын дараа цэвэр ус, бүлээн цай уудаг болсон. Биеийн байдал ч дээрдэж байна. Муу зуршлаа бага багаар хаяаарай. /18 настай Камила/

2. "Өөрийгөө ойлгож сурсан нь"

Өнгөрсөн улирлын хичээл миний хувьд хар дарсан зүүд байв. Эцэг эхтэйгээ муудалцаж, санхүүгийн дарамтад орж, найзуудтайгаа таагүй харилцах болов. Өдөр бүр шахуу архи, пивоор сэтгэлээ тайтгаруулсаар нэг л мэдэхэд уухгүй байж чадахаа байв. Өөрийгөө сонсохоо больж, хамгийн сүүлд хэзээ өөртэйгөө ярилцсанаа ч мартав. Үүнийгээ анзаарснаар би өөртөө дүгнэлт хийж, нэг шөнийг л өөрийн доторх хүнээ сонсоход зарцуулснаар амьдралаа өөрчилсөн. Архиар аргацаалгүй өөрийгөө сонсон, бодлоо чагнаж, тэмдэглэл хөтлөх таны санаанд оромгүй гайхалтай үр дүн бий болгохыг санаарай. /20 настай Нето/

3. "Архи уулгүйгээр нээлттэй байж чаддаггүй зуршлаа ялан дийлсэн нь"

Насанд хүрмэгц хууль ёсоор архи, согтууруулах ундаа хэрэглэхийг зөвшөөрдөг тул би төрсөн өдрөөрөө үүнийгээ тэмдэглэн, үнэхээр их уусан юм. Анх удаа л архи ууж

байсан учир сэтгэл санаа тайвширч, мансууран, олон хүнтэй танилцаж, найзуудтайгаа тун хөгжилтэй нэг үдшийг өнгөрүүлсэн. Энэ өдрийг би дурсахдаа олон дахин уух болж, нэг л мэдэхэд уулгүйгээр чөлөөтэй биеэ авч явж чадахаа байсан. Гэвч би 22 нас хүрсэн жилдээ огт архи уухгүй байхаар шийдсэн юм. Ингээд л "архичин би" биш, эрүүл саруул "Би" ч хөгжилтэй, нөхөрсөг нэгэн болохоо найзууддаа батлан харуулсан юм даа. /23 настай Бруно/

4. "Зүүрмэглэх зуршлаа хаясан нь"

Өдрийн цагаар нойр их хүрдэг тул хичээлтэй үеэр арын ширээнд суугаад дугхийчихдэг байв. Багшийн үнэлэмж, сурлагад сөргөөр нөлөөлж байсан тул би өөртөө зорилго тавьж, нойр хүрэх бүрт аяга ус уудаг болсон. Илүү сэргэлэн цовоо болж, өнгөрсөн улиралд дажгүй оноо авсандаа баяртай байна. /18 настай Цезар/

5. "Тамхинаас гарсан нь"

Тамхинаас гарахаар 2 жилийн өмнө шийдсэн ч гарч чаддаггүй байлаа. Гэвч саяхнаас татах тамхиа өөрөө ороох болсноор бага багаар гарч байна. Тамхи ороох тийм ч хялбар биш тул аажмаар залхуутай санагдаж, тамхийг үзэн ядахад минь тусалж байна гэхэд болно. Дажгүй санаа биш гэж үү? /25 настай Тортела/

6. "Хэт их идэх зуршлаа ялсан нь"

Өглөө, өдөртөө хангалттай цаг зав байдаггүй тул юм идэж чаддаггүй байв. Үүний улмаас орой гэртээ харьмагцаа хэт их идэж, шөнө ходоод өвдөн, улмаар багагүй таргалсан. Тиймээс би өөрийгөө хайрлаж сурахаар шийдэж, хэдий завгүй ч хамаагүй жимс, самар гэх мэт эрүүл хүнс цүнхэлж, хаа нэг заваараа идчихдэг болсон. Ингээд орой зохих хэмжээнд хооллоод л болох нь тэр. /27 настай Лорена/

7. "Өдрийн 80 хувийг ашиглаж сурсан"

Фэйсбүүк, нийгмийн сүлжээнд ихэнх цагаа өнгөрүүлдгээс өөртөө анхаарал тавих, гоо зүй, ухаан мэдлэгээ дээшлүүлж чаддаггүй байв. Гэвч өдөр бүр тэмдэглэл хөтлөх болсноор өдрийн 80 хувийг өөртөө зориулж сурлаа. /17 настай Лезиль/

8. "Сэрүүлгээ хойшлуулахаа больсон нь"

Өглөө сэрэх миний хамгийн том асуудал. 5 минут, 10 минут гэсээр нэг л мэдэхэд хичээлээсээ хоцорчихдог байв. Гэвч сэрүүлгэнийхээ хойшлуулах товчийг дарахаа больсноор л энэ асуудал шийдэгдсэн юм даа. Та ч бас хэрэгжүүлээд үзээрэй. /15 настай Натали/

9. "Бусдын бодлыг чухалчлахаа больсон нь"

Миний хувьд бусдад таалагдах, тэдний юу гэж бодох нь маш чухал байв. Хувцас авахдаа, гадуур явахдаа, үзэл бодлоо илэрхийлэхдээ ч найзууд, гэрийнхнээсээ асуулгүйгээр шийдвэр гаргаж чаддаггүй нь өөрт минь маш их дарамтыг бий болгож байсан. Нэг л өдөр би энэ бүхнээс залхаж "Надад хамаагүй" гэж хэлж сурсан. Би бусдыг хүндлэх ч тэдний бодлоор амьдрахад дэндүү хайран хүн шүү дээ. /19 настай Батиса/

10. "Найз залуугаа бүх амьдралаа болгохоо больсон нь"

Миний хувьд хайр дурлал бүх амьдрал минь байв. Найз залуутайгаа л байвал эцэг эх, гэр бүл хамаагүй болж, түүний төлөө ажлаасаа хүртэл гарав. Гэвч эцэст нь би ганц бие, амиа хоохойлсон, арчаагүй нэгэн болон хоцорсон. Тэгээд би сайн дурын ажил хийх болж, гэрийнхэн, найз нөхдөө илүү ихээр хайрлахаар шийдсэн. Энэ үед л би хайр зөвхөн үерхэлд байдаггүйг, бидний сэтгэл зүрхэнд хангалттай их халуун дулаан илч нуугдан байдгийг ухаарсан юм. /22 настай Нина/

“НОМТОЙ НӨХӨРЛӨӨ” АЯНЫ ХҮРЭЭНД

Хорих анги, байгууллагуудад ял эдэлж буй хоригдлуудын мэдлэг боловсрол, өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх, тэдний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “НОМТОЙ НӨХӨРЛӨӨ” 45 хоногийн аяныг зохион байгуулахаар 2020 оны 05 дугаар сарын 15-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа.



445 дугаар нээлттэй хорих анги



445 дугаар нээлттэй хорих анги нь аяны хүрээнд хоригдлын ном унших орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор “Жин царс бат” ХХК, “Бат” групп болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж тэдний дэмжлэгээр нийт 12,0 сая төгрөгийн өртөг бүхий 3000-3500 орчим номын багтаамжтай, 20-25 хоригдолд үйлчлэх номын сангийн засвар, үйлчилгээний ажлыг 2020 оны 06 дугаар сарын 10-наас 28-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулж, номын фондыг шинэчлэн нэмэгдүүлэхэд анхаарч “Номын өглөг” сэдэвт аяныг төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, алба хаагчдын нарын дунд 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд аяныг зохион байгуулж нийт 732 ширхэг ном, сэтгүүл хандиваар цуглуулан өнөөдрийн байдлаар тус газрын номын санд 1750 ширхэг ном, 600 гаруй цахим номыг компьютерт байршуулан хоригдлуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч тодорхой үр дүнтэй ажлыг зохион байгуулан ажиллаж аяныг тэргүүлсэн юм.

401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн нийгмийн ахлах ажилтан, сэтгэл зүйч нь 3 сая төгрөгийн төсөл бичиж, төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр 36 мкв бүхий сургалтын танхимын зориулалтаар ашиглаж болохуйц 300 ширхэг номтой номын санг шинээр тохижуулж ашиглалтад оруулсан.



401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг

Харин 407, 415, 417, 421, 429, 439, 441, 445 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд хоригдлын ном унших орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч номын санд засвар үйлчилгээ хийж тохижуулж, 12 хорих анги төрийн бус байгууллага, алба хаагчдын хандиваар 7004 номыг цуглуулж номын баяжилтыг нэмэгдүүлсэн байна.

Засвар үйлчилгээ хийсэн хорих ангиудын зургуудаас:



417 дугаар нээлттэй хорих анги



425 дугаар нээлттэй хорих анги



429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг



415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

Аяны хүрээнд хоригдлуудын ном унших сонирхол, сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хоригдол нэг бүрийг номтой нөхөрлүүлж, уншсан номын тэмдэглэлийг хөтлүүлэх, бяцхан ном урлах, уншсан номын агуулгад тулгуурлан эссэ бичлэг, гар зураг, шүлгийн уралдаан зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулахаас гадна уншсан номын тэмдэглэл, хийсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж идэвхтэй оролцсон хоригдлуудыг шагнаж урамшуулан тэдэнд урам зориг өгч цаашид ном унших сэдлийг төрүүлсэн ажлуудыг зохион байгуулсан байна.

Аян зохион байгуулснаар 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг номын сан ашиглалтад оруулж, бусад хорих анги байгууллага номын санд засвар үйлчилгээ хийн, орчин нөхцлийг сайжруулж, номын баяжилтийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болсон юм.

НОМ БОЛ ЕРТӨНЦИЙГ ХАРАХ ЦОНХ ЮМ

СҮРВАЛЖЛАГА

ХОРИГДЛУУДЫН ЦУЛАСАН БҮТЭЭЛЭЭР “МӨРӨӨДЛИЙН БАЙШИН” СЭДЭВТ ҮЗЭСГЭЛЭН ГАРГАЛАА



Жил бүрийн 8 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Ням гаргагт тохиодог Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны өдрийг тохиолдуулан байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс, 405 дугаар хаалттай хорих ангитай хамтран Монголын уран зургийн галерейтэй хамтран хоригдлуудын урласан бүтээлээр “Миний мөрөөдлийн байшин” үзэсгэлэнг гаргалаа.

Тус үзэсгэлэнд 407, 409, 415 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хорих ял эдэлж буй хоригдлуудын урласан эсгий, цаасан урлал, уран зураг, хатгамал, сийлбэр, уран дархан, наамалаар урласан 50 гаруй бүтээлүүд дэлгэгджээ. Мөн уран зургаар дамжуулж хоригдлыг төлөвшүүлэх ажлын хүрээнд дуу хөгжим, уран зураг хоёрыг хослуулан сэтгэл заслын бясалгалыг явуулсан нь үр дүнтэй болсныг онцолж байна.

Мөн энэ үеэр 405 дугаар хаалттай хорих ангийн алба хаагчдыг “Урлагаар анагаахуй” эвент хөтөлбөрт хамруулсан. Энэхүү хөтөлбөрт хамрагдсанаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид урлагаар дамжуулж хүнд хэрхэн нөлөөлөх арга барилыг суралцсан. Сургалтад 25 алба хаагч хамрагдаж Монгол зураачдын сор болсон бүтээлүүдийг үзэж сонирхож, урлаг хэрхэн хүнд нөлөөлдгийг харуулсан театрчилсан жүжгийг үзэж сонирхжээ.

Үзэсгэлэнгийн үеэр Монголын Уран Зургийн Галерейн захирал Б.Сарантуяа, 405 дугаар хаалттай хорих ангийн нийгмийн ахлах ажилтан, хошууч Д.Баярбаатар нартай уулзаж, ярилцаж сэтгэгдлийг нь сонслоо.

Монголын Уран Зургийн Галерейн захирал Б.Сарантуяа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны өдрийг тохиолдуулан “Миний мөрөөдлийн байшин” үзэсгэлэн 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд Монголын уран зургийн галерейд зохион байгууллаа.

Энэхүү үзэсгэлэнд тавигдсан “Миний мөрөөдлийн байшин”-г урлахад хоригдлуудад маш их итгэл найдвар төрүүлсэн болов уу. Энэ нь хүний оюун ухаанаас гарч буй урлагийн бүтээл юм. Тийм учраас өөрөөсөө урган гарч байгаа сайн үзүүрийг өөрийн мөрөөдөлтэй хослуулан бүтээл ажил хийж байгаа тэр хугацаанд нь тэднийг бүтээл туурвих сайн тал руу нь оруулж байна, итгэл үнэмшил төрүүлж байна, суллагдан гараад яг л ийм байшинд амьдарна гэж дотоод сэтгэлдээ хэдэн жил, сараар мөрөөдсэн мөрөөдлөө бодит зүйл болгосон нь сэтгэл зүйн сэтгэлгээний маш том засал болсон гэж бодож байна.

405 дугаар хаалттай хорих ангийн нийгмийн ахлах ажилтан, хошууч Д.Баярбаатар: ШШГЕГ-ын 405 дугаар хаалттай хорих анги нь Монголын уран зургийн галерейтэй хамтран хоригдлуудыг урлагаар дамжуулж сэтгэл засал, зан байдлын төлөвшил, амьдралын зорилго хүсэл мөрөөдлийг өөрчлөх “Миний мөрөөдлийн байшин” 45 хоногийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн. Хөтөлбөрт хамрагдсан хоригдлууд өөрийн ирээдүй, хүсэл мөрөөдлийг цаас болгондоо шингээж хийсэн ба энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон хоригдлуудын бүтээлээр Монголын уран зургийн галерейд үзэсгэлэн гаргана гэдэг маань бидний хийсэн ажил сайн үр нөлөө үзүүлсний тод жишээ юм. Мөн 45 хоногийн хугацаанд өөрийнхөө сэтгэлийг шингээн дотоод нөөц бололцоогоо ашиглан хийсэн нь нийгэм, сэтгэл зүйд нь эерэг нөлөө үзүүлсэн гэдгийг хэлэх нь зүйтэй.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СҮМ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТЭС-423 ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ

Энэ удаагийн дугаарт Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын ажлыг онцлолоо.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хорих анги нь 1979 оноос эхлэн мод үржүүлэг, мод бэлтгэх, зүсмэл үйлдвэрлэх, гэр ахуйн өргөн хэрэгцээний модон эдлэл, гэрийн мод хийж ирсэн ба өнөөдрийн байдлаар тус ангийн мужаан цехэд сийлбэртэй, иж бүрэн тавилгатай 6, 8 ханатай гэр, дүнзэн торх, бэлэг дурсгалын зүйл, зэс домбо, мөнгөн хундага, мөнгөн тоногтой бүс, эмээлийн баавар, дөрөө, хувин, давсаар хийсэн бэлэг дурсгалын зүйл, суран хазаар, сүлжмэл хазаар, бугуйл, ташуур, олом, жирэм зэрэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



Гар урлалын цехэд 165 хоригдлыг мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хамруулан ажлын байраар хангаж, хаягдал нэхийний ноосыг хяргаж, угааж цэвэрлэн самнаж эсгий хийн хөвлүүрийн шаахай, эсгүүрийн шаахай, эсгий бойтог, арьсан гутал, ширмэл ширдэг ширэх, зүү ороосон арьсан бүс, зүү ороосон бурхан бүтээх, бэлэг дурсгалын зүйлс хийх, эсгий зураг зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.



Ангийн нарийн ногооны хүлэмжээс өргөст хэмх, улаан лооль, сонгино, лууван, манжин, гоньд зэргийг хураан авч өргөст хэмх 800 шил, алаг салат 64 шил, хүрэн манжин 24 шилийг тус тус даршилсан. Ногооны талбайгаас төмс, байцаа, лууван, улаан манжин, шар манжин зэрэг хүнсний ногоог хураах ажил явагдаж байна.



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ


Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж буй хоригдлуудаас улс орны бүтээн байгуулалтад оролцож байна.

Завхан аймгийн Идэр сумын Загастайн даваа Өвөр нумын Баян гэх газар 20 хоригдол, Завхан аймгийн Улиастай сум Жэгэстэй баг гэх газар 20 хоригдол замын туслах ажил, ус зайлуулах хоолойны арматур зангидах, цутгах, хэвлэх ажил, чулуу бэлтгэх, материал ачих буулгах зэрэг туслах ажилд, Баянхонгор аймгийн Бууцагаан сумаас Говь-Алтай аймгийн Дэлгэрэх сум хүртэл 120 км хатуу хучилттай замын гүүр хоолойн бетон дүүргэлт, цутгалтын ажилд 48, нийт 88 хоригдол зохих харуул хамгаалалтын хяналтад улс орны бүтээн байгуулалтад ажиллаж байна.



Эдгээр 88 хоригдолд 110.690.400 төгрөгийн цалин бодогдсоноос гэм хорын төлбөртэй 38 хоригдлын 17.895.795 төгрөгийн төлбөрийг төлж барагдуулан, 38 хоригдлын ар гэрт 14.068.890 төгрөгийг шилжүүлсэн.

Мөн хорих ял эдлүүлэх албанаас баримталж буй бодлого чиглэл хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, цагдан хорих байранд хүнийг нөхцөлөөр нь эрүүдэн шүүх асуудлыг эцэслэн шийдвэрлэх, нэгдсэн жишиг стандартад хүргэх, үүрэг даалгаврын хүрээнд цагдан хорих байрыг засварлах, "Хорих өрөөний хаалга, цонхны төмөр сараалжин хаалтад тавигдах ерөнхий шаардлага" стандартыг хэрэгжүүлэхэд анхаарч 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хооронд засвар, бүтээн байгуулалтын ажлыг хуяглан хүргэлтийн ажилтан, дэслэгч Л.Цогбаяр хариуцан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааг өдөр бүр амаар болон бичгээр ажлын байрны хөдөлмөрлөх нөхцөлд тохируулан өгч осол аваар гаргалгүй ажилласан.



Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор Хархорин сумын хаус хороололд 17х9 харьцаатай, 153м2 талбай бүхий төвийн цэвэр, бохир, дулааны шугамд холбогдсон, автомашины гражтай, 3 айлын хаус барилгын ажилд хөнгөлөлттэй үнээр хоригдол ажиллуулан 100 хувь гүйцэтгэн ашиглалтад оруулсан.



Ангийн нэг цэгийн үйлчилгээнээс шалган нэвтрүүлэх байр хүртэлх 110м шороон замыг аспалтан зам болгон шинэчилсэн



НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

2013 оноос эхлэх Өвөрхангай аймгийн Политехникийн коллежтой хамтран ажиллаж жилд 3 ангид 65-75 хоригдлыг тогооч, нарийн боов үйлдвэрлэл, сантехникч, модон эдлэлийн мужаан, арьсаар гар урлалын зүйл урлаач, гуталчин, хөдөө аж ахуйн фермер, гагнуурчны мэргэжил олгох сургалтад амжилттай хамруулж мэргэжил эзэмшүүлж бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлж, зөв амьдрах арга ухаанд сургасан.

2019-2020 оны хичээлийн жилд талх, нарийн боов үйлдвэрлэлийн ажилтан мэргэжлээр 24, модон эдлэлийн мужаан мэргэжлээр 23, арьсаар гар урлалын зүйл урлаач мэргэжлээр 20, нийт 67 хоригдлыг мэргэжил эзэмшүүлсэн.



Хоригдлуудыг сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх тэдэнд боловсролын болон хөдөлмөрийн дадлага чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллаж байна.



Хоригдлын амьдралын бүсэд сэтгэл зүйн мэдээлэл бүхий ханын самбарыг шинэчлэн танин мэдэхүй, мэдээ мэдээлэл, сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөмж хийж, хоригдлын тав тухтай орчинг бүрдүүлэн, сурч боловсрох, хувь хүний зан үйл, харилцаа хандлага дээшлүүлэх, зорилгоор видео сургалтын тэнхимийг бүрэн засаж тохижуулан, сэтгэл зүйн тэнцвэрт байдлыг хангах, хувь хүнийг төлөвшүүлэх, сэтгэл зүйн тэнцвэрт байдлыг хангахад бясалгалын танхимыг засварлан ажилласан.

“ГАЛЕРЕЙ АЯЛЖ БАЙНА” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД...

Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс нь Монголын уран зургийн галерейн “Монгол уран бүтээл”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийн хүрээнд соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, Монголын уран зургийн галерейн дүрслэх урлагийн шилдэг бүтээл музейн зөөврийн үйлчилгээг алслагдсан болон тусгаарлагдсан хүн амд хүргэх, үйлчлэх, уран зургаар дамжуулан сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх, амьдралын үнэ цэнэ, мөн чанар, утга учрыг ойлгуулах, дотоод мэдрэхүйг сэргээн эмчлэх, соён гэгээрүүлэх зорилготойгоор “Галерей аялж байна” хөтөлбөрийн хүрээнд 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад дараах үйл ажиллагааг зохион байгуулаа.



Үүнд: “Уран зураг”-аар дамжуулан хоригдлын стрессийг бууруулах, сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх, амьдралын үнэ цэнэ, мөн чанар утга учрыг ойлгуулах, дотоод мэдрэхүйг сэргээн эмчлэх, соён гэгээрүүлэх; Хувь хүний хөгжилд зориулсан хөтөлбөрийн хүрээнд “Хөгжимтэй зураг”, “Бүлгийн сэтгэл заслын уулзалт”, “Агшин зуурт амар амгаланд хөтлөх зам бясалгал” гэсэн үе шаттайгаар зохион байгуулаа.

“Хөгжимтэй зураг” нь хоригдлын сэтгэлийн ерөнхий төлөвт тохируулан сонгосон уран зургийн бүтээл болон тэдгээрийн утга, агуулгад нийцсэн хөгжмийн хэмнэлд хоригдол ганцаарчлан төвлөрснөөр үүсэх мэдрэмж, сэтгэл зүйн үйлчилгээгээр дамжуулан өнгөрснөө эргэн харах, сайн сайхан дурсамжаа сэргээх, өнгөрсөн, одоо, ирээдүйн тухай эргэцүүлэх,



“Бүлгийн сэтгэл заслын уулзалт” нь хоригдлын харилцан ярианы сэдэв, агуулга, ярих ярилцах, сонсох үйлийг удирдан чиглүүлснээр, сайхан дурсамжийг сэргээх, эерэгээр сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, талархах, бусдыг үнэлэхгүйгээр сонсож ойлгох, хандлагаа өөрчлөх,



“Агшин зуурт амар амгаланд хөтлөх зам бясалгал” нь хоригдол өөрийн дотоод ертөнцөд гэрэл түгээх, өөрийгөө мэдрэх, дотоод итгэлийг нэмэгдүүлэх, тайвшрах, сэтгэл зүйн таатай байдлыг мэдрүүлэхэд тус тус чиглэгдсэн байна.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад үлгэрийн цаг буюу “Үдийн хоолонд зочилсон хурга” хүүхдэд зориулсан сэтгэл зүйн театрчилсан жүжгийг, жүжигчин З.Адьяатөмөр, Ч.Дүүриймаа нар нийт өсвөр насны 32 хоригдолд үзүүлсэн.



ҮЙЛ ЯВДЛЫН МӨРӨӨР

ХОРИГДЛЦУДЫГ КЕРАМИК ЦУРЛАЛЫН СУРГАЛТАД ХАМРЦУЛЖ БАЙНА

Хоригдлын засрал хүмүүжилд эерэг нөлөөлөл үзүүлэх тэдний мэдлэг боловсрол, бие даах чадварыг сайжруулах цаашлаад өөрсдийн сурч мэдсэн чадвараараа ажлын байр бий болгон нийгэмд бие даан амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор “Керамик урлал”-ын сургалтыг хорих ангийн орчин нөхцөлд зохион байгуулж байна. Тус сургалтад 6 хоригдлыг хамруулж, шавраар бүтээл урлаж байна.



Керамик урлал нь хүнээс асар их тэвчээр мэдрэмж сэтгэхүй шаардсан урлаг бөгөөд хүн юу хүсч мөрөөдөж төсөөлж байгаагаа шавраар урлаж, давтагдашгүй бүтээл гардаг гэдгээрээ онцлогтой. Энэхүү урлагт суралцсанаар аливаад тэвчээртэй, хүлээцтэй хандах хандлага төлөвших, уур бухимдалаа зохицуулж сурах, гоо зүйн мэдрэмж нэмэгдэх, шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм. Керамик урлалын шавар нь энгийн шавартай харьцуулахад барьцалдах чанар сайтай, хатуулаг чанартай байдаг. Тиймээс бүтээл туурвих шаврыг урьдчилан бэлтгэж боловсруулдаг.

Сургалтад хамрагдсан хоригдлуудын хувьд илдүүр, хэвлэх, дамрын болон ороох аргаар бүтээлээ урлаж байгаа бөгөөд сийлбэрч, зураач, мужаан зэрэг гарын ур дүйтэй хоригдлыг сонгосон. Цаашид сургалтын үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхээр зорьж байна. Энэ урлагийг бясалгалын нэг төрөл гэж хэлж болно. Өнөөдөр бидний сонгож авсан хоригдлууд бүтээлээ туурвиж байхдаа асар их тайвшрал, сэтгэл санааны төлөвшлийг авч байгаа нь харагддаг.

Сургалтын арга хэлбэрийн хувьд 30 хувь нь онолын мэдлэг олгох, 70 хувь нь практик дадлага олгох хэлбэрээр явагддаг байна. Эрхээ хязгаарлуулж, нийгмээс тусгаарлагдсан хэдий ч сурч боловсрох эрхийнхээ хүрээнд ял эдлэх хугацаандаа мэргэжил олгох сургалтуудад хамрагдаж, суллагдан гараад эзэмшсэн мэргэжлээрээ ажил хөдөлмөр эрхлэн сайхан амьдрах боломж бүрджээ. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд анх удаа хэрэгжүүлж байгаа Керамик урлал буюу шавар урлалын сургалт 429 дүгээр хаалттай хорих ангид амжилттай явагдаж байна.

“ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР ЦУРШИГ” СЭДЭВТ ЭССЭ БИЧЛЭГИЙН ЦУРЛДААНЫГ ЗОХИОН БАЙГЦУЛЛАА.

Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь тус аймгийн Прокурорын газартай хамтран хоригдлуудын дунд “Гэмт хэргийн хохирол, хор уршиг” сэдэвт ЭССЭ бичлэгийн уралдааныг 2020 оны 08 дугаар сард зохион байгуулж дүгнэлээ. Уралдаанд 131 бүтээл ирсэнийг Говьсүмбэр аймгийн Прокурорын газар, ангийн удирдлагууд дүгнэж 1, 2, 3, тусгай байрыг шалгаруулан 4 хоригдолд батламж олгосон.



Ангийн удирдлагын шийдвэрээр шалгарсан ЭССЭ-г хоолой бичүүлэн нийт хоригдлуудад радиогоор сонгосон. 2 дугаар шатанд шалгарсан 36 хоригдлын ЭССЭ-г нэгтгэн тохимол болгон хэвлүүлэхэд бэлэн болоод байна. Хоригдлууд ЭССЭ бичихдээ гэмт хэрэг үйлдсэнээр өөрсдөө болон өрөөлийг хэрхэн хохироодог, нийгэмд болон цаашлаад улс орныхоо хөгжилтөнд маш их хохирол учруулдаг талаар өөр өөрсдийн санаа бодлоо дэлгэрэнгүй илэрхийлсэн байлаа. Энэ нь бусад хоригдлуудад гэмт хэргийн хор уршигийн талаарх ойлголтыг өгсөн эерэг нөлөөлөл, хүмүүжлийн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа боллоо.

“ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ ТӨХӨӨРӨМЖ”-ИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЛЭЭ

Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2020 оны 08 дугаар сараас эхлэн хоригдол, хоригдогч нарын эрхийг хангах, тэдний зан үйлд нөлөөлөх сургалт хүмүүжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах зорилгоор тус газрын цагдан хорих байранд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн зарлан мэдээлэх төхөөрөмж хүлээлгэн өгснийг Цагдан хорих байрны 17 хорих өрөөнд радио үзэл, сургалт явуулах дэлгэцийг тус тус байрлуулан ашиглаж байна.



Зарлан мэдээлэх төхөөрөмжийг ашиглан цагийн хуваарьт үйл ажиллагаанаас гадна хоригдол, хоригдогчдын сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэхүйц Цагдан хорих байрны дотоод цагийн хуваарь, зан үйлд нөлөөлөх сургалт, хоригдогчдын эрх үүрэг, танин мэдэхүйн сургалт, сурталчилгааг тусгай хөтөлбөр гарган видео хэлбэрээр явуулж байна.

ХҮМҮҮЖИГЧИЙН БУЛАН

Салжээ

Хайрт ээж Д.Сарангэрэлийнхээ
гэгээн дурсгалд зориулав!

Хүйн холбоогоор цөглөгдөж хүн болсон бие минь
Хүж дэлхийн хэвлийд гагнагдан ирчхээд
Хатуутай, зөөлөнтэй хорвоогийн араншинг
Хараагүй өнгөрсөн минь учиртай л юм шиг ээ
Амьдралын жолооноос атгасан алдхан бие минь
Анивчих оддын гялбаанд аргамжлагдан байхад
Алдаатай оноотой аргаар жамыг
Анзаараагүй явсан минь учиртай л мэт ээ...

Ээжээ!

Бүүвэйн дуунд тань уясаж орчлонг бүүвэйлэхэд
Нэхий өлгийнд минь хорвоо тэр чигээрээ багтдаг байсан
Хүн бие минь бойжиж хөрст шороог тамгалахад
Хөхүүрийн айраг исэх шиг хорвоод хүү нь сагаж байсан
Араг үүрч аргалд цуг явахдаа баярлаж аньсага чийгтэхэд
Арагт тань амьдрал тэр чигээрээ үүрлэж байсан
Аргалын гал тулганд дүрэлзэж халуун төөнөхөд
Амьдрал өлмийд минь мөргөж байсан

Ээжээ!

Буурал ижий таныхаа ангир уургийг амтлахад
Буцах шувуудын араас сүү тань цагаан зам татуулдаг байсан
Өтөл ижий таныхаа энгэр өөд эрхлэхэд
Өнгөт орчлон өвөрт минь жаргадаг байсан. Гэвч
Өдөр өдрийн нар зулай дээрээс гийхэд
Өтөл таны минь буурал санчиганд буурал сор буусан байсан
Зуун найман суваргатай зулын дөл бадамлан байхад
Зүрхэн цэцэг тань зурагтай л хамт үлдсэн байсан...

Даанч!

Гурван арвантай цаг цагийн аясаар
Газар цөмөрч, тэнгэр ниргэх шиг
Газар тэнгэрийн савслагад үүлэн сүүдэр бууна гэж санаагүй л
Гашуудлын цуваанд харууслын нулимс унагана гэж бодоогүй л...
Одоо тэгтэл оддын гялбаанаас алдхан биеэ аргамжиж
Орчлонг бүүвэйлнэ гэдэг яасан хэцүү юм бэ?
Хүж дэлхийн хэвлийд хүн биеэ гагнаж
Хөрст шороог тамгална гэдэг юутай гаслам бэ?

Ээжээ!

Хүний хүүхдүүд шиг ижий таныгаа жаргааж чадаагүйдээ
Хүү нь өөртөө л гомдож сууна
Хүрэн зүрхээ эгшээж, халуун цусаа царцтал
Гашуун нулимс унагаж л сууна

Ээжээ!

Гомдол нэхэхгүй би алагхан хорвоогоос
Гашуун нулимс нэрж аргаар жамыг ч зуурахгүй
Ганган цэцгийн дэлбээг солонгоруулан байж хорвоогийн араншинг ч аргадахгүй
Ганцхан удаа л харж гараас тань л атгахсан

Ээжээ!

Буйдхан диваажингийн цэцэрлэгт хүрээлэнгээс
Бурхан гэгээн Ногоон дарь эхийн амгалан дүрээр
Бяцхан үрээ энхрийлж үнэрлэн, эрхлүүлэн жаргаах гэж
Будант алсын харгуйгаас та минь хүүдээ хааяахан ирдэг ээ
Зүүдний ертөнц хоромхон зуур байдаг шигээ
Зүүдэнд ирж уулзаад буцаад явах бүрд тань хүү нь баярладаг шүү
Гэлээ ч, дөнгөж саяхан дэргэд минь байсан таныгаа санаад сэрэхэд
Дэр минь өнчин нулимстай нууранд нэвчсэн байдаг шүү

Ээжээ!

Бурхан ижий таныхаа өлмийд тань зуун найман удаа сөгдөн мөргөөд
Булбарай үр нь танаасаа уучлал гуйя!
Буцах шувуудын тэргүүнд нь үгээ дайж
Бурхан гэгээн дүрээ тань уучлал гуйя!

Ээжээ! Хүү нь

Эргэх дөрвөн цагийн зурлагад гурван арванг үдэхдээ
Ижий тантайгаа дандаа хамт байх юм шиг санаж
Эрээвэр хураавар амьдралыг мөнхөд өлмийнд минь мөргөж байх юм шиг андуурч
Энэхэн биеэ жаргааж явж байсныхаа төлөө
Танаасаа өршөөл эрье!
Уучилж өршөө ээжээ!!!

Ээжээ!

Намрын хүйтэн бороо цас болон будрахад
Найргийн өчүүхэн төгөл сэтгэлд минь нялхарч таныгаа санана
Нялх багын дурсамж хорвоотой хамт үлдсэн
Нэхий өлгийгөө энгэртээ нааж таныгаа үгүйлнэ
Үгүйлэн санахад
Үлдсэн амьдралдаа
Ээжээ...гээд дуудаад байхад эрхлүүлээд үнэрлэх
Ивийдээ... гээд энхрийлж
Зулайг минь илэх Ижий минь та дэргэд үгүй ч
Тэнгис далайн усан огторгуйгаас
Тал дүүрэн цэцэгс дэлгэрүүлж
Шүлгэн эрхээр үгэн суварга босгосон шүлгээ тэврээд
Тандаа хүү нь золгоно оо Ээжээ!

2020 оны хаврын тэргүүн сар. Хайрт хүү Ш.Шинэтүлгас.
427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

Э. Мөнөнхуяг: Хэн нэгэн чамд бүү хийнээсэй гэж хүсэх муу зүйлийн өөрөө л бусдад битгий хийнээрэй

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь нийт хоригдлуудын дунд "Миний өөрчлөлт" сэдвээр эссэ бичлэг, "Аз жаргалтай гэр бүл" сэдвээр бүтээлийн уралдаан зарлахад нийт хоригдлууд идэвхтэй оролцож хоригдол Э.Мөнөнхуяг тэргүүлсэн байна.

"Миний өөрчлөлт" эссэ бичлэгийн уралдаанд 1 дүгээр байрт шалгарсан хоригдол Э.Мөнөнхуягтай уулзаж ярилцахад:

Энхбат овогтой Мөнөнхуяг миний бие нь 1993 оны 2 дугаар сарын 17-ны өдөр төрсөн. Миний хэлэх дуртай үг бол "Үг гэдэг хүчтэй хүнийг алж ч чадна амьдруулж чадна", сонирхол ширээний теннис, биллиард тоглох дуртай. Бусад хоригдож байгаа хоригдлуудад хандаж хэлэхэд: "Хүүхдүүддээ хоол хийж өгөхөд ааваа идээд дууссан гэхэд ямар их баярладаг байсан гээч. Тэр л зүйлийг хэрэглэдэг болсноос хойш амьдралаас таашаал авах мэдрэмж байхгүй болсон байсан. Анх би 2017 оны сүүлээр баригдахдаа, ингээд л шоронд орж дээ гэж бодож байсан л даа. Тэгсэн үгүй юм байна лээ. Хамгийн анх хар тамхи хэрэглэсэн тэр мөчөөс хойш би өөрийгөө хүсэл зорилго аз жаргалыг толгойн дотроо хорьчихсон байсан юм байна лээ. Одоо би хамгийн түрүүнд толгойн доторх түгжээний түлхүүрийг л хайж олох хэрэгтэй гэж бодоод эрэн хайж байгаа."

"Миний өөрчлөлт"

2012 оны 11 дүгээр сарын 04-ний энэ өдөр надад сайхан мөч тохиож байсан юм. Хамгийн анх "Аав" болж үгээр хэлэмгүй баяр тохиож билээ. Элэг бүтэн амьдрал аз жаргал юугаар ч сольшгүй нандин бүхнээ би өөрийн тэнгээс болж нэг зүйлээр сольж алдсан юм. Энэ бол хар тамхи, өөрийгөө надад юунаас ч илүү гэж хуурч байсан зүйл. Энэ л зүйлтэй байхад надад юу ч хэрэггүй мэт. Хар тамхины хамааралтай тэр бүх л хүмүүсийг би удирдаж чадаж байх нь надад маш их таалагдаж яг л өөрийгөө хаан болсон мэт санагдаж, энэ л мэдрэмжийг алдахаас айж жил гаруй хугацаанд би их зүйлийг алджээ.

Одоо би нийгмийн эсрэг гэмт хэрэгтэй, хоригдол нэртэй хүмүүжигч. Яагаад вэ? гэж үү, яагаад гэвэл улсын зөвлөн бодлого буюу чимээгүй дайны гүүр болж "ЦАГААН ТАХАЛ" тарааж байсан болохоор тэр. Монгол улсын өмч иргэн бид хар тамхины хараат болж эдийн засгийн хямралд орвол, эх орон маань дагаад уналтад орох үндэслэл юм байна. Валют (мөнгө) ний ханш, доллар, юанийн ханш өсөөд байгаа юм биш. Монгол төгрөгийн ханш унаад байгаа юм.

Энэ бол жишээ нь эх орон минь колони хараат улс болвол яах вэ? Өвөг дээдсийнхээ цусаа урсгаж байж үлдээсэн газар чөлөөтэй явж гишгэх завдалгүй, "хөөе энэ бол миний газар чи дээр нь бүү яв, даруй холд гэхвий гэхээс би одоо айж байна. Одоо би нэрийг нь ч сонсохоос айх тэр зүйлээс ангижраад 2 жил болж байна. Урд нь тэр зүйлгүйгээр өөрийгөө хэн ч бишээр төсөөлж байсан бол, эрүүл саруул ухаанаар бүгдийг нь харж сэтгэж байна. Энэ зүйл бидний зүрх, тархинд нөлөөлж ухамсрын доройтолд оруулж цаашлаад үр удамд хүртэл үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулах хор хөнөөлтэй бодис юм байна.

Алдаа гаргасан үедээ түүнийгээ ухамсарлаж ойлгосон л бол эхлээд өөрсдийгөө уучилцаа. Хүн алддаг, алдаан дээрээсээ суралцдаг шиг би бусдын алдаан дээр нь бас суралцаж байна. Бид өөрөө өөрийгөө өөрчилж чадна. Өөр хэн ч биш. Гагцхүү үүнд л таны миний чин хүсэл зүтгэл л хэрэгтэй. Хэн нэгэн чамд бүү хийгээсэй гэж хүсэх муу зүйлийг өөрөө л бусдад битгий хийгээрэй. Одоо би буруу бүхний өөдөөс үгүй гэж хэлнэ. Чи бид нар яг одоо амьд байна гэдэг нь өөрөө хамгийн их аз завшаан юм. Хийж байгаа үйлдлээрээ хүн өөрийгөө бүтээдэг. Би одоо өөрийгөө цагаан хөдөлмөрөөр бүтээнэ. Надад хайртай бүх хүмүүсийн төлөө.

Энэ бүх үзэл бодлын өөрчлөлтийг би хорих ангийн нийгмийн ажилтнуудын шат дараалсан сургалтуудаас би олж ойлгож авсан юм. Мөн хүнд нэг хором ямар их үнэ цэнэтэй болохыг мэдэж авлаа. Нэг хоромын уур бухимдал нэг насны харамсал дагуулдаг юм байна. Одоо бид харуусалгүй, харж амьдарья. Аз жаргалыг хором хормоор амсаж мэдэрье. Магадгүй маргааш танд эрх чөлөө олгогдвол цаг хугацааг алдаж болохгүй шүү. Цаг бол алт цагийг хожвол бүхнийг хожно шүү залуусаа.

(Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХ-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хүмүүжигч Э.Мөнөнхуяг)

Хуульсаа хуртэй биднээс нуурж авдаг ээжийнхээ

Хуурын ус иш тундгай хайрын нь дээдэрж авсаарай

Хуур хуртэй шувуудаа хууэн зүүрхдэй энэ хорвоод

Хууийн дундах ганц бурхан ээжийнээ хайрлаж авсаарай



САГСАН БӨМБӨГИЙН ТҮҮХ


СПОРТЫН МЭДЛЭГТ



Тоглоомын энэ төрлийг сэдэж олох үйл ажиллагаа 1891 оноос эхэлсэн. АНУ-ын Массачусетс мужийн Спрингфилдийн Залуу христосчуудын холбооны коллежийн удирдлага зохион байгуулагч гишүүд спорт зааланд явагдаж байсан биеийн ерөнхий хөгжлийн дасгалуудаас түргэн уйдах болсон. Коллежийн оюутнууд намар нь Америк хөл бөмбөг, хавар нь хөнгөн атлетик, бейсболоор хичээллэж, харин өвөл нь зөвхөн зааланд гимнастикаас өөр хичээллэх спортын төрөл байсангүй. Иймд залуучуудын сонирхлыг татах шинэ зүйл чухал шаардлагатай байлаа. Тус коллежийн биеийн тамирын хэлтсийн ахлах, нарийн бичгийн дарга доктор Лютер Хелси Гулик сэтгэл судлалын семинар дээр өвлийн улиралд битүү, хиймэл гэрэлтүүлэгтэй зааланд залуучуудын сонирхлыг татахуйц шинэ тоглоомын төрлийг сэдэж олохыг зөвлөсөн. Ингэж Гуликийн заавраар биеийн тамирын багш Жэймс Нейсмит 1891 оны өвөл тоглоомын шинэ төрлийг санаачилж "Сагсан бөмбөг"-ийг тоглоход амархан, харин сайн эзэмшихэд хэцүү гэж тодорхойлж байжээ. Ж.Нейсмийн гавьяаг үнэлэн Спрингфилдийн коллеж 1911 онд "Биеийн тамирын хүндэт мастер", 1936 онд Мак Гиллын Их сургууль "Анагаах ухааны доктор" цолоор тус тус шагнасан байна.



1968 онд Спрингфилдын коллежийн дэргэд Ж.Нейсмийн музейг байгуулсан бөгөөд хожим нь "Сагсан бөмбөгийн алдрын танхим" гэж нэрлэгдэх болсон. Ингэж хүн төрөлхтөнд гайхамшигт сайхан тоглоомыг бэлэглэсэн энэ хүнийг мөнхжүүлэн хүндэтгэл илэрхийлсэн юм. Ж.Нейсмит 1861 онд Канад улсад төрөөд 1939 онд нас барсан. Мэдээж тоглоомын шинэ төрлийг сэдэж олохын тулд эрт дээр үед Америк тивд дэлгэрч байсан бөмбөгтэй тоглоомын түүхэн мэдээ баримтуудыг ашигласан нь ойлгомжтой. Жишээ нь одоогоос 2000 жилийн тэртээ Мексикийн нутаг дээр амьдарч байсан Инк Майя гэдэг овгийнхон "Пок-то-пок" бөмбөгтэй тоглоом тоглож байжээ. Тоглоомын гол зорилго нь эгц босоо хананд байрлуулсан чулуун цагирагт бөмбөгийг шидэж оруулах явдал байлаа. Мөн XVI зууны үед Ацтекууд "Оллмалитули" нэртэй тоглоом каучукан бөмбөгөөр чулуун цагирагт шидэн тоглож байсан байна. Ж.Нейсмит заалын тагтан /балкон/ дээр жимсний 2 сагс байрлуулаад бөмбөг шидүүлдэг байсан. Гимнастикийн заалны тагтны өндөр 3 м 05 см байсан ба энэ хэмжээ одоо хүртэл сагсан бөмбөгийн цагиргийн өндөр болон хадгалсаар үлджээ. Бөмбөгийг сагсанд шидэж оруулж байсан учраас /Basket –сагс, ball-бөмбөг/ сагсан бөмбөг нэрийг олжээ. Ж.Нейсмит 1891 оны XII сард шинэ тоглоомынхоо дүрмийг бичиж анхныхаа тэмцээнийг зохион байгуулж, 1892 онд сагсан бөмбөгийн дүрмийн номоо хэвлүүлжээ.



Энэ дүрмийн ном нь 13 зүйлээс бүрддэг бөгөөд эдгээрийн ихэнх нь орчин үеийн сагсан бөмбөгийн дүрэмд үйлчилсээр байна. 1895 оноос эхлэн цагиргийг самбарт бэхлэх болсноор тэмцээний дүрэмд бага зэрэг өөрчлөлт орсон. Тагтан дээр зогсоод тэмцээн үзэж буй сэтгэлийн хөдөлгөөнтэй хөгжөөн дэмжигчид заримдаа өөрийнхөө багт туслах зорилгоор бөмбөгийг барьж авч эсрэг багийнхаа цагирагт хийдэг байсан тул цагиргийг хамгаалах зорилгоор самбарыг ашиглах болжээ.

Сагсан бөмбөгийн хөгжил

Хөгжлийн явцад тоглолтын дүрэм, тоног төхөөрөмж, тамирчдын хувцас хэрэглэл, өөрчлөгдөн хөгжсөөр иржээ. 1893 онд анх тортой төмөр цагираг, 1894 онд бөмбөгний тойрог 76,2-81,3 см хэмжээтэй болсон. 1895 онд анх 15 футээс торгуулийн шидэлт хийж эхэлсэн.

Хөгжлийн үе шат

I үе шат 1891-1918 он.

Тоглоомын шинэ төрөл бий болсон. Сагсан бөмбөг нь өөрийн бүхий л онцлогоороо ялгаран спорт тоглоомын биеэ даасан төрөл болж хөгжсөн. Америкийн нэгдсэн улс даяар түргэн тархахын зэрэгцээ бөмбөг барих, дамжуулах, шидэх зэрэг техникүүд гарч ирсэн. Тактикийн хувьд тоглогчдыг Довтлогч, Хамгаалагч гэж ангилах болжээ. Сагсан бөмбөг нь Европ, өмнөд Америкт өргөн дэлгэрч эхэлсэн.

II үе шат 1919-1931 он.

Сагсан бөмбөгийн үндэсний холбоод шаардлагатай болсон. 1927 онд Женевт Спрингфилдын доктор Элмер Берригаар удирдуулсан биеийн тамирын боловсрол олгох сургууль байгуулагдсан. Тус сургуулийн гол зорилго нь Европ болон бусад тивүүдэд сагсан бөмбөгийг дэлгэрүүлэх явдал байлаа. Сагсан бөмбөг нь Чехословак, Латви, Эстони, Литва, Итали, Франц зэрэг орнуудад өргөн дэлгэрэхийн зэрэгцээ олон улсын нөхөрсөг уулзалт тэмцээнүүд зохиогдох болсон. 1919 онд Америк, Итали, Францын армийн шигшээ багуудын дунд олон улсын анхны тэмцээн зохиогджээ.

III үе шат 1932-1947 он.

Сагсан бөмбөгийг дэлхий нийтээр хөгжүүлэх үе. 1932 оны 06 дугаар сарын 18-нд сагсан бөмбөгийн түүхэн гайхамшигт үйл явдал болсон нь Олон Улсын Сагсан Бөмбөгийн Холбоо /ФИБА/ байгуулагдсан явдал юм. 8 орны (Аргентин, Грек, Итали, Латви, Португали, Румын, Швейцари, Чехословак)-ын үндэсний холбоодын төлөөлөгчид оролцсон олон улсын бага хурлаар ФИБА-г байгуулсан тухайгаа санал нэгтэй мэдэгдэж албан ёсныхоо дүрмээ баталсан. 1935 онд Олон улсын олимпын хороо сагсан бөмбөгийн спортыг олимпын төрөлд оролцох шийдвэр гаргаж улмаар Берлинд болсон Олимпын XI тоглолтод 21 орны баг тамирчид оролцоноос Америкийн

баг аварга болжээ. Тус тоглолтод I Дж.Нейсмит хүндэт зочноор оролцсон байна.

IV үе шат 1948-1965 он.

Техник тактикийн ур чадвар эрс нэмэгдэж сонирхогчдын ба мэргэжлийн сагсан бөмбөг гэсэн 2 чиглэлээр хөгжих болсон. Тоглогчдын техник, тактикийн ур чадварыг огцом нэмэгдүүлэхэд доорх хүчин зүйлүүд чухал нөлөө үзүүлсэн.

- Америкт Үндэсний сагсан бөмбөгийн холбоо /NBA/
- Мэргэжлийн клубууд байгуулагдсан
- Нэг гараар шидэх техник өргөн дэлгэрсэн
- Довтолгоог төвийн тоглогчоор дамжуулан явуулах иж бүрэн тоглолтын систем шинээр хэрэглэгдэх болсон. Эдгээр нь сагсан бөмбөгийг цаашдын хөгжилд өвөрмөц хувьсгал болсон юм.

Америкийн дасгалжуулагч Т.Арчер 1948 онд анх "Мини сагсан бөмбөг"-ийг санаачилсан. Энэ нь зөвхөн 8-12 насны хүүхдийг сагсан бөмбөгийн спортоор хичээллүүлэх зорилготой гарч иржээ. Тоглолтын дүрмийн хувьд хялбарчилсан, жижиг бөмбөгтэй /67-72 см тойрогтой, жин нь 450-500 гр/, цагиргийн өндөр нь 2 м 60 см, самбараас торгуулийн шидэлтийн шугам хүртэл 4 м зайтай ажээ. 1950 онд Аргентинд эрэгтэйчүүдийн, 1953 онд Чилид эмэгтэйчүүдийн дэлхийн аварга шалгаруулах анхны тэмцээнүүд зохиогдож Аргентин /эрэгтэй/, Америк /эмэгтэй/ багууд аварга болж байжээ. 1950 оны эхээр сагсан бөмбөгт довтолгоо зонхилоход нөлөөлөх хүчин зүйлүүд гарсан нь:

- Довтолгооны техник тактик, хамгаалалтын техник тактикаас давамгайлж ирэв.
- Багуудад өндөр нуруутай тоглогчдын эзлэх хувь нэмэгдсэн 1965 онд ФИБА –д дэлхийн 122 орон гишүүнээр элссэн байлаа. V үе шат 1965 оноос хойших үеийг сагсан бөмбөгийн спорт өөрийнхөө өмнө тулгарсан асуудлуудыг даван туулж ид хөгжлийнхөө замд шилжсэнд тооцдог.

Монголд сагсан бөмбөгийн спорт хөгжсөн түүх

1940 -өөд оны эцсээр манай оронд уригдан ирж ажиллаж байсан Зөвлөлт, Хятадын мэргэжилтнүүд, ажилчид чөлөөт цагаараа сагсан бөмбөг тоглож тэднээс офицерийн сургуулийн сонсогчид, зарим залуучууд суралцаж байснаар анхны эх үүсвэр нь тавигдсан гэх боловч хэрэглэл материал муутай, заал талбай цөөн байжээ. 1946 онд явагдсан улсын анхдугаар спартакиадад спортын сайн дурын "Соёл", "Хөдөлмөр" зэрэг нийгэмлэгүүдээс тэр үеийн волейболын тэмцээнд оролцож байсан тамирчдаас бүрдсэн багууд сагсан бөмбөг тоглож байжээ. 1954 онд улсын аварга шалгаруулах албан ёсны анхны тэмцээн явагдаж үүнд нийгэмлэгүүдийн эрэгтэй, эмэгтэй багууд оролцон "Соёл" нийгэмлэгийн эрэгтэй баг аварга болжээ. 1959 онд зохиогдсон Монголын Залуучууд Оюутны анхдугаар их наадмын тэмцээнд "МУИС", "Барилгачин", "Залуучууд" багууд тэргүүн байрт шалгарч байжээ. 1961 оны Монголын бүх ард түмний анхдугаар спартакиадаар хот хөдөөгийн 24 нийгэмлэг, 6 их дээд сургуулийн эрэгтэй эмэгтэй 60 гаруй багийн нийт 400-аад тамирчид оролцож хотоос, МУИС-ын багийн ахлагч С.Чоён анхны спортын мастер цол хүртсэн. 1962 онд БНМАУ-ын Сагсан бөмбөг сонирхогчдын холбоог байгуулсан. 1950-иад оноос ардын армийн шугамаар манай тэргүүний сагсан бөмбөгчид Хятад, ЗХУ, Европын социалист орнуудад очиж нөхөрсөг уулзалт тэмцээнд оролцож өөрийн оронд ах дүү армиудын болон бусад баг тамирчдыг урьж уулзалт тэмцээн зохиодог болсон нь тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, залуучууд өсвөр үеийнхнийг сагсан бөмбөгийн спортоор шимтэн хичээллэхэд ихээхэн түлхэц болсон юм. Манай улсын сагсан бөмбөгийн хөгжилд Алдар нийгэмлэгийн оруулсан хувь нэмэр их билээ. 1994 онд МСБХ шинэчлэгдэн зохион байгуулагдаж Монголын сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг анх санаачлан ажилласан. МСБХ нь 2000 оны 12 дугаар сарын 21 –нд Азийн сагсан бөмбөгийн холбооны 44 дэх, 12 сарын 29 –нд олон улсын сагсан бөмбөгийн холбооны 144 дэх гишүүн орноор тус тус элссэн билээ.



МОНГОЛ НААДГАЙ

Монголчуудын тоглоом наадгай нь нүүдэлчдийн амьдрал ахуйд тулгуурласан, тоглох аргын хувьд төгс боловсорсон оюуны чухал соёлын өв ажээ. Монгол тоглоомын дотор эртний хүмүүсийн амьдрал үйл ажиллагааны шууд тусгал болон зохиогдсон тоглоом олон байдаг. Тухайлбал, чулуугаар бай оных, чулуу өнхрүүлэн уралдуулах, чулуугаар ус алгадуулах зэрэг тоглоом нь ан агнах, араатнаас биеэ хамгаалах үйл ажиллагаанаас үүсжээ. Монголчуудын тоглоом наадгайг насанд хүрэгчдийн ба хүүхэд залуучуудын гэж ангилдаг ба тэдгээрийг шагайн тоглоом, чулуун тоглоом, аман тоглоом, хөлөгт тоглоом, гар хуруугаар тоглох тоглоом, хөдөлгөөнт тоглоом, гэр барих тоглоом, оньсон тоглоом гэх мэтээр ангилдаг. Ардын тоглоомын санд 15 бүлгийн 800 гаруй тоглоом байдаг байна. Түүний дотор зөвхөн хөлөгт тоглоом гэхэд 130 гаруй нэр төрөл бий. Мал сүргээ маллаж өсгөх, ан гөрөө хийх, ах захаа хүндлэх ёсыг хэвшүүлэхийг үлгэрчлэн харуулах зэрэгт монгол тоглоом хүмүүжлийн чухал ач холбогдолтой.

Оюун ухаан хөгжүүлэх оньсон тоглоомоороо Монгол улс дэлхийд дээгүүр байранд ордог. Модоор хийдэг нь хүүхдэд ямар ч хоргүй, оюун ухааныг тэтгэхээс гадна гарын булчин шөрмөсийг ч хөгжүүлдэг давуу талтай. Оньсон тоглоомыг 3, 6, 9, 12, 32 модны гэхчлэн ялгадаг. Гадна хэлбэрийн хувьд ч маш олон янз бий. Монголын уламжлалт оньсон тоглоомыг урлах 3000 төрлийн арга буй хэмээн үздэг.

Шагайгаар наадах 80 орчим төрлийн тоглоом бий бөгөөд эртний уламжлалтай. Морь уралдуулах, бөгцөг няслах, шагай шүүрэх зэргийг мэдэхгүй хүн ховор. Анд боллоцхдоо шагай солилцдог байсан нь нэгэн биеийн холбоотой хоёр мөч мэт салшгүй байхын бэлгэдэл байжээ.

Оюун түлхүүр: Хүн бүр бие барсныхаа дараа тамын оронд заавал очдог хэмээн нэгэн домогт өгүүлдэг. Тамын орон нь газрын гүнд оршдог, есөн үетэй гэнэ. Үе бүр нь өлсөх, цангах, даарах, халууцах гээд өөр өөрийн зовлонтой. Хэцүү бэрхийг туулан есөн үеийг давсан хүн диваажинд очих жамтай. Тамын орноос гарах сүүлийн хаалгыг оньсоор цоожилсон байдаг. Ган төмрөөр хийсэн тэрхүү бат бөх цоожийг онгойлгоход ямар ч багаж хэрэгсэл, түлхүүр нэмэргүй. Зөвхөн хурц ухаантай, уйгагүй хөдөлмөрч хүн л цоожийг тайлах учиртай ажээ. Оюун түлхүүр тоглоомын түүх ийм. Эцэг эхчүүд нь энэхүү тоглоомыг тоглох аргыг хүүхдүүддээ хэзээ ч зааж өгдөггүй. Хонь малаа бэлчээхээр явахад нь "Үүний учрыг нь ол" хэмээн өгч явуулдаг байжээ. Үүнийг мөн чамбалын түлхүүр гэж нэрлэх нь ч байдаг байна. Уг тоглоом нэг оньсыг тайлахаас эхлээд хэдэн зуун үйлдэлтэй цагираг болтлоо хөгжжээ. Гэхдээ үхлийн дараах амьдралд бэлдэхээс илүүтэй үр хүүхдийнхээ гүйлгээ ухаан, тооцоолох чадварыг хөгжүүлэхийн тулд оюун түлхүүрийг тайлуулдаг байсан нь ойлгомжтой.



Оньсон тоглоом: Оюун задлах оньсон тоглоомоороо монгол дэлхийд дээгүүр байрт жагсдаг. Энэхүү уламжлалт тоглоомыг модоор хийдэг тул хүүхдэд ямар ч хоргүй, оюун ухааныг тэтгэхээс гадна гарын булчин, шөрмөсийг ч хөгжүүлдэг давуу талтай гэнэ. Дэлхийн олон оронд оньсон тоглоом түгсэн ч дийлэнх нь дүрс, хэлбэрийн хувьд нэгэн хэвийн шинжтэй байдаг. Тэгвэл "Олон улсын оюун ухааны музей"-н захирал З.Түмэн-Өлзий шатрын хөлгийн ширээг оньслон бүтээж, Сүхбаатарын хөшөөнөөс эхлэн Эрх чөлөөний хөшөө, Эйфэлийн цамхгийг ч оньсон тоглоом болгон урлажээ. Уг тоглоомыг гурван модны, зургаа, ес, 12, 32 дүрстэй гэхчлэн ангилдаг. Түүнээс гадна хэлбэрийн талаас тоймгүй олон янз байдаг. Учир нь тухайн зохион бүтээгчийн санаа, үр хийцээр баяждаг байна. З.Түмэн-Өлзий Монголын уламжлалт оньсон тоглоомыг урлах 3000 төрлийн арга буйг тогтоон, гэрчилгээг нь авчээ.



Алаг мэлхий өрөх: "Эрхийн чинээ биетэй, эрдэнийн дөрвөн талтай" шагай нь уламжлалт тоглоомын эртний төрлүүдийн нэг юм. Амьтны шаант ясны үзүүрт оршдог жижиг цул яс буюу шагайгаар наадах 80 орчим төрлийн тоглоом бий. Морь уралдуулах, бөгцөг няслах, шагай шүүрэх зэргийг мэдэхгүй хүн ховор биз. Эрт дээр үед анд боллоцхдоо шагай солилцдог байсан нь нэгэн биеийн холбоотой хоёр мөч мэт салшгүй байхын бэлгэдэл байжээ.



Монголчууд алаг мэлхийг битүүний орой өрж, шинийн нэгэнд тоглодог уламжлалтай. Энэхүү тоглоомыг хэдэн ч хүн тоглох боломжтой бөгөөд 92 эсвэл 108 шагайгаар өрнө. Тоглогчид ээлжээр шоо хаяж, хоёр нүхээр буувал нүд, чих, бөөр зэрэг хос эрхтний аль нэгийг авах боломжтой. Хэрэв зургаагийн тоо буувал хүзүү, нурууны аль нэг эгнээний зургаан шагайг өөрийн болгодог. Хамгийн олон шагай хожсон хүн ялагч болно. Түүнчлэн шагай дуусахад дахин тоглох бөгөөд шооны нүхний тоогоор өрнө. Хэрвээ хоёр буулгавал нүдийг, гурав бол толгой, дөрөв байвал шилбэ зэргээр мэлхийн дүрсийг гаргадаг. Шагайн наадгай нь хүүхдийг дэг журамтай болгож, нүдний харааг сайжруулж, ажигч гярхай болгоход дөхөмтэй гэнэ.

Үйчүүр: Үйчүүрийг хөзрийн хамгийн эртний хэлбэр гэдэг. Энэхүү тоглоом багаар ажиллах, түргэн сэтгэх, шийдвэр гаргах, цээжээр зөв бодох, тооцоолох чадварыг эзэмшүүлдэг байна. Үйчүүрийн мод тус бүрт шувуу, туулай, хүдэр, харцага, буга, ирвэс, арслан, үнэг, нохой зэрэг амьтныг танин мэдүүлдэг ажээ. Уг наадгайг тэгш тоогоор талцан тоглодог.



Амьтдыг зургаар нь ангилан тавьж, зургаан ширхэг шоог нар зөв тойруулан ээлжлэн хаяна. Амьтан бүр тоотой. Жишээ нь: дөрвөн нүхтэй зургаан ширхэг шоо буувал нэг арслан авна. Нэг арслан нь 64 лантай тэнцдэг нь тэмцээний хамгийн өндөр оноо. Хоёр нүхтэй шоо хоёр буувал нэг нохой авна. Нэг нохой нь 12 лан ажээ. Тоглоом дуусахад хожсон амьтдынхаа тоог гаргаж, ланг тогтоон дүнгээ гаргадаг.

Монголын уламжлалт тоглоом "Үйчүүр" нь Цагаан сарын шинийн нэгэнд тоглогддог хүндтэй тоглоомын нэг бөгөөд шооны нүд болгон нь урам зориг, хийморь бэлгэдлийг илэрхийлдэг. Энэ тоглоомын ач тус нь багаар ажиллах, түргэн сэтгэх, шийдвэр гаргах, цээжээр зөв тооцоолох бодох чадварыг хөгжүүлдгээрээ онцлогтой.

"Үйчүүр"-ийг 7x10 сантиметрийн хэмжээтэй цаасан дээр зурж, тэмээний яс болон модон дээр сийлж хийдэг. Энэхүү тоглоом нь амьтдын дүрсээс бүрдэх бөгөөд дүрсийг лангаар үнэлнэ. Үйчүүр"-ийг нутаг нутагт өөрөөр тоглодог. Тоглох нэг арга нь 2-6 тоглогч бүх модоо дундаа өрж, ахмадаасаа эхлэн нар зөв тойруулан 6 шоог аяган дотор ээлжлэн орхиж, буусан нүдний нийлбэрт тохируулан газрын модноос лангаар үнэлж авна. Тоглоомын төгсгөлд олон лан авсан хүн хождог. Үйчүүр тоглоомыг хатуу цаасан зурах эсвэл модонд сийлдэг. Модонд сийлбэртэй нь эдлэлээ удаантай байдаг. Баян-Өлгий, Увс аймгийн музейд сийлбэртэй үйчүүр байдаг.

Үйчүүрт нийт Арслан, Бар, Ирвэс, нохой, үнэг, буга, хүдэр, бялзуухай зэрэг 134 ширхэг мод, 512 лангийн үнэлгээтэй амьтад байдаг.

Монголын нутаг болгонд үйчүүрийг өөр өөрөөр нэрлэж, үйчүүрт дүрслэх амьтад ч өөр байх нь бий. Хүн хар гөрөөс гэх мэт ч дүрслэлтэй үйчүүр ч байдаг.

Энэ тоглоомын үндсэн ач холбогдол нь цээжээр тоо бодуулах юм. Хэдэн ч хүн тоглож болдог. Тоглогчдын хамгийн отгоноос эхлэн 4 ширхэг шоо хаяна. Шоо нь улаан, хар нүдтэй. Одоо хэрэглэдэг шоотой ижил боловч улаан хар нүдний өнгө зөрүүтэй. Буусан улаан, хар нүдний нийлбэрээс хамааран лангаар үнэлэгдэх амьтаас авна. Зарим нь буцааж өгөх буюу торгуулах, шооны нийлбэрт нь таацах амьтан байхгүй бол өнжих зэрэг тохиолдол гардаг. Хөвсгөл нутагт шооны нүдний нийлбэр үнэг, нохой буувал торгуультай. Өмнө цуглуулсан амьтаасаа буцаан тавьдаг.

Амьтад тус бүр үнэлгээтэй учир бүх амьтад дуусахад хамгийн их лан цуглуулсан хүн хождог. Арслан хамгийн том мод. Арслан авсан хүн хожигдвол "хамуурлаа" гээд гурван жил авдартаа хадгалдаг уламжлалтай. Зуны цагт тоглуулдаггүй байв.

Хорол: Даалуу хэмээх наадгай Монгол Манжийн үед түгжээ. Тэр үед монгол ноёд, бүсгүйчүүд даалуугаар мөрийтэй тоглодог байжээ. Харь улсын хорон явуулгаас үндэстнээ хамгаалах зорилготой хүмүүс хамтран хорол хэмээх тоглоомыг бүтээсэн түүхтэй. Уг тоглоомд 12 жилийн амьтны дүрсүүд, эрхэм шударгын хорол, эрдэнэсийн бэлгэдэл чандмань, амар жаргалын өлзий хээ гурван толгой мод байна. Зарим нутагт хас, очир, цэцгийн дүрсийг ч оруулдаг. Хорлыг тоглохдоо моднуудыг доош харуулан тарааж, 5-6-гаар давхарлан өрнө. Ингээд тойрч суусан хүмүүсээс ахмад настай нь эсвэл шодож таарсан хүн нь тараадаг. Эхний хүн модыг дангаар эсвэл ижилсүүлэн гаргаж, дараагийнх нь тэндээс сонгох буюу дагуулж өгнө. Ийм маягаар гэр барьж, хэн олон гэртэй болсон нь хождог ажээ. Хорол хамтач ёс, бие биенээ хүндэтгэх зан төлөвшүүлэхэд ач холбогдолтой. Орлолчид тоглоомын явцад "12 жил" дууг мөн харилцан дуулдаг юм байна. Мөн даалууны мод бүрд зориулсан орчин үеийн үг хэллэг ч бий болжээ.



Уран бэрийн гогцоо: Монголчууд бэр болох хүнийхээ гадаад үзэмж, биеэ авч явах байдал, ажилсаг чанараас гадна оюун ухааныг нь харгалзан тоглоомор шинждэг байжээ. Чөмөгний ясны хоёр талын гогцоонд тус тусдаа буй шагайг нэг утсанд оруулж чадвал уран ухаантай бүсгүй байна хэмээн үнэлдэг байжээ. Ээдрээ тайлах төрлийн тоглоомд үүнээс гадна бөгж нийлүүлэх, цагираг чөлөөлөх зэрэг багтдаг. Энэ төрлийн наадгай нь юмыг гярхай ажиглах чадвар, олон талаас эргэцүүлэн бодох, ой тогтоолт, уйгагүй оролдлогыг сайжруулдаг байна.





БАРИЛГЫН САНТЕХНИКИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, БАЙГУУЛАМЖИД АЖИЛЛАХ ҮЕИЙН

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЖИЛЛАГАА

Сантехникийн хэрэглээ:

Өнөө үед дэлхий нийтэд барилга, байгууламжийн сантехникийн систем нь маш өндөр хэмжээнд хөгжиж шинэ техник технологи, хийц эдлэл болон тоног төхөөрөмжүүд нэвтэрч байна.


Манай улсад 1950 оны сүүлээр сантехникийн систем тавигдаж, өнөөдрийг хүртэл хөгжиж ирсэн. Сантехник гэдэг нь эрүүл ахуйн техник гэсэн үг юм. Төвлөрсөн дулаан хангамж, халаалт, усан хангамж, ариутгах татуургын систем, агааржуулалт, халуун усан хангамжийн систем зэрэг нь нэгдэж сантехникийн системийг бүрдүүлдэг.

Сантехникийн систем нь тоног төхөөрөмж, хийц эдлэл, дамжуулах хоолой, эх үүсвэр гэсэн гурван үндсэн хэсэгт багтана. Сантехникийн системийн үндсэн ажлын бие нь ус, уур, хий, агаар бөгөөд эдгээрийг хатаах, хөргөх, цэвэрлэх зэргээр параметрийг нь өөрчлөн системд хэрэглэдэг юм.

Худагт ажиллах бригад салааны бүрэлдэхүүн



Зөөврийн анхааруулах тэмдэг



Бохир ус зайлуулах системийн худагт орж ажиллах үеийн хөдөлмөр хамгаалал

Бохир ус зайлуулах худагт орж ажиллах бригад 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба нэг нь худагт нөгөө нь газар дээр ажиллаж гуравдах хүн нь тэдгээрийн ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай үед худаг доторх ажилчинд тусламж үзүүлнэ.

Ажилчин худагт орохдоо хамгаалалтын бүс бүсэлж оосрыг худгийн дээр гаргасан байна. Бригадын гишүүд нь ажил эхлэхийн өмнө ажлын байрыг халхлах хэрэгсэл хайс, өдрийн цагт улаан цагаан өнгөөр ялган будсан, шөнийн цагт аккумуляторын дохиоллын гэрэлтэй эсвэл автомат дохиололтой зөөврийн гурван хөлтэйг тавина.

Худагт ажиллах үеийн хөдөлмөр хамгаалал

Хүнд хий нь бохир усны гадаргууд хуралдах ба түүнийг гар сэнс эсвэл тусгай машин дээр суурилуулсан цахилгаан дамжуулагчтай АВМ-2, РВМ-2 гэх мэт агаар үлээгчийн тусламжтай зайлуулна. Хийг зайлуулсаны дараа сүлжээний агаарт хий байгаа эсхийг дахин шалгана. Худагт орох үедээ болгоомжтой байж ил гал гаргасан гэрэлтүүлэг авч худагт орох, худаг дотор ил гал гаргах, онгорхой худгийн дэргэд тамхи татахыг хориглоно.

Газар шорооны болон өндөр, хүйтэнд ажиллах үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа

Газар доорх ашиглагдаж буй шугам сүлжээ бүхий бүсэд газар шорооны ажлыг гүйцэтгэхдээ уг байгууламжийг эзэмшигч байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч газар доорх барилга байгууламжийг барьж байгуулсан зургийг сайтар судалж шугам сүлжээ байгаа газрыг тусгайлан тэмдэглэж хамгаалах хязгаар тогтоон хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа уг ажлыг гүйцэтгэнэ.

Газар шорооны ажил гүйцэтгэх бүс нь эргэн тойрондоо найдвартай хашилт, хамгаалалт хийгдсэн хөдөлгөөний чиглэл талд 5 м-ээс багагүй зайд анхааруулах тэмдэглэгээ, эргэлтэй болон нарийссан хэсэгт 1.5 м өндөрт анхааруулах улаан тэмдэг тавьсан байна.

Ашиглагдаж байгаа шугам сүлжээ байгаа бүсэд газар шорооны ажлыг мастер, даамлын хяналтан дор гүйцэтгэх бөгөөд харин тэдгээрт ойртсон үед хариуцсан хүмүүсийн хяналт дор эсвэл уг шугамыг бүрэн тасалж ажлыг гүйцэтгэнэ.

Бохир ялзмаг үнэртэй болон оршуулгын газар зэрэг халдварт өвчин тарааж болзошгүй хөрстэй орчинд газар шорооны ажил гүйцэтгэхийн өмнө улсын эрүүл ахуйн хяналтын газраас заавал зөвшөөрөл авсан байна.

Ухан нүх шуудууны амсар ирмэгээс 1м-ээс бага зайд элдэв зүйл хураах, ойр явах, 2м-ээс дотогш зайд машин механизм байрлуулах, багаж хэрэгсэл, материал бусад зүйлийг суваг, шуудуу руу шидэж өгөхийг хориглоно. Хөрсийг хөндийлэн ухсан нүх, шуудууны ханыг налж суухыг хориглоно.

Нүх шуудуунаас гарч буй шороог ухаасын ирмэгээс 0.5м-ээс багагүй зайд зайлуулж асгана. Чулуу, бөөгнөсөн элс шороог хүчтэй хол шидэн хаяхыг хориглоно.

1.3м-ээс дээш гүнтэй ухаасанд ажилчдыг оруулж ажиллуулахын өмнө ханын бэхлэгээний бат бөх, хөрсний налуу, тогтворжилтыг заавал шалгана.

Хөрсний усны түвшингээс дээш байрлах газар доорх байгууламжаас хол газарт хадан бүс болон цэвдэггүй хөрсөнд дараах гүнээс илүүгүй үед бэхлэгээгүй босоо ханатай нүх ухаж болно. Үүнд:


- асгаадын элс, том ширхэгийн хөрсөнд -1м,
- элсэрхэг хөрсөнд - 1.25 м,
- шаварлаг болон шавар хөрсөнд-1.5 м байна.

Хөрсний бэхлэгээг ухаасын дээд ирмэгээс 15см-ээс багагүй дээш гарган дээрээс нь эхлэн хийнэ. Ухаасын ирмэг буюу хөрсний налууны давхаргад нуран өнхрөх чулуу болон бусад зүйл байвал тэдгээрийг урьдчилан зайлуулах шаардлагатай. Хөрсний хананд ан цав хөндийрөлт үүссэн байвал урьдчилан нурааж аюулгүй болгоно.

Барилгын талбай дах ухмал худаг, нүх шуудуу, өрөмдсөн газар бусад ухаас зэрэг хүн унаж болзошгүй газруудад таг, бат бэх хашлагаар хаалт хийж анхааруулах тэмдэг тавьсан байна. Шөнийн цагт 2 м өндөрт байрлуулсан 42 В-оос дээшгүй хүчдэлтэй дохионы цахилгаан чийдэнгээр орчныг гэрэлтүүлсэн байвал зохино.

Гудамж, гарц, оршин суугч ихтэй хашаа талбай, тээврийн болон явган зорчигчдын хөдөлгөөн ихтэй газруудад нүх, суваг шуудуу ухвал хамгаалалтын хашаа, хашилт хийж эргэн тойронд нь урьдчилан сануулсан таних тэмдэг санамж бичиж тавина. Явган зорчигч шуудууг хөндлөн гарах шаардлагатай газарт 1 м-ээс багагүй өндөр зориулалтын хашлагатай 0.5-1.0м өргөнтэй гүүрэн гарцуудыг хийж шөнийн цагт заавал гэрэлтүүлнэ.

Бэхлэгээгүй ухсан нүх, суваг шуудууны ойролцоо машин, механизмыг байрлуулах шилжүүлэн ажиллуулахдаа хөрсний нуруалт үүсэхээс болгоомжлох шаардлагатай.



Хөрсний шилтгэлийн коэффициент

0.15 м зууны давхарга хүртэл халаа

Хөрс	Сугарилтын гүн (м, илүүгүй)		
	1.5	3	5
Овоолсон натаршлаггүй	10.65	11	11.25
Элсэрхэг айргатай	10.5	11	11
Элсэрхэг	10.25	10.67	10.85
Шаварлаг	10	10.25	10.75
Шавар	10	10.25	10.5
Алтан киларх	10	10.5	10.5

Газар доорх хамгаалах бүсэд, хятаг байвал газар шорооны ажлыг инженер техникийн ажилчид шууд үндэсд өгнө. Өндөр түрлийн дор жижиг хийн хоолойны дор байрлах сабелийн хамгаалагч бүсэд, тэрхүү газар шилтгэлийн болон хийн ажилтан байх ёстой.

0.3 м босоо түнд хүртэлх үе. Лом, татуу, нураах ажил хэрэгтэйг хоригло.

Хайсны тугаа жижиг дивартай бичин сагийг найдвартай оосор шуудуу руу булга.

Краныг шуудуу, суурийн нүхний захад аюулгүй зайд байрлуул

Суурийн нүхэнд хүмүүс байхгүй үед хөрсний болон бул чулууны үлдэгдлийг нураана.

Хөрсөн доогуур малтаахыг хориглоно.

Харангуй шуудууноо гранаа гэрэлтүүлж гэр тусарна.

Суурийн нүхэнд сууриас тусгай хэсгийг ноосоор хийсэн чимхэт хүртэл. Зөвхөн илчийн дараа тусгай сулал болно.

Бэхлэгээний байгууламжийг барихдаа завсарлага хийлгүйгээр дуусгах хэрэгтэй.

№	Овоолгосон хөрсний зай, А				
	Хөрс хатуу	Элсэрхэг	Шаварлаг	Шавар	Талын талбай
1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5

